


# НОГООН БИЧИЛ САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН



2020 он



## АГУУЛГА

ТАЛАРХАЛ	6
СУДАЛГААНЫ БАГ	7
ОРШИЛ	8
СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ	9
СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ТҮҮВЭР	10
СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ	11
СУДАЛГААНЫ ҮР ДҮН	15
СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ	51
САНАЛ ЗӨВЛӨМЖ	54
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	56

## График, хүснэгтэн мэдээллийн жагсаалт

График 1 Хуулийн этгээдийн хэлбэрээр	16
График 2 Хуулийн этгээдийн байршлаар	16
График 3 Үйл ажиллагаа явуулж буй жилээр	16
График 4 Судалгаанд оролцогч зээлдэгчийн тоогоор	16
График 5 МУ-н ББСБ-н ногоон индекс ба SPI4-ийн ногоон индексийн харьцуулалт	17
График 6 Байгаль орчны гүйцэтгэлийн индексийн харьцуулалт	18
График 7 Ногоон индексийн үнэлгээ - ББСБ-ийн хувиар	19
График 8 Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ - стандарт тус бүрээр	19
График 9 Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ - ББСБ-н бүс нутгаар	21
График 10 Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ статусаар	22
График 11 Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ - хугацаагаар	23
График 12 Стандарт 1-ийн үзүүлэлт тус бүрийн дундаж үнэлгээ	24
График 13 Судалгаанд оролцогчдын байгаль орчны стратегийг тодорхойлж, удирддаг байдал	25
График 14 Стандарт 2-ын гүйцэтгэлийн үзүүлэлт тус бүрийн дундаж үнэлгээ	27
График 15 Судалгаанд оролцогчдын байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг байдал	27
График 16 Стандарт 3-ын гүйцэтгэлийн үзүүлэлт тус бүрийн дундаж үнэлгээ	29
График 17 Судалгаанд оролцогчдын байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг байдал	30
График 18 Стандарт 3-ын гүйцэтгэлийн үзүүлэлт тус бүрийн дундаж үнэлгээ	32
График 19 Судалгаанд оролцогчдын ногоон боломжийг дэмжиж урамшуулдаг байдал	33
График 20 Экологийн дотоод ул мөрийг хянахад хялбар болон ШГ-д хэрэгтэй эсэх	34
График 21 Цахилгаан, ус, цаас, шатахууны хэрэглээний өөрчлөлтийг хянадаг эсэх	35
График 22 Сургалтын үйл ажиллагааг хянахад хялбар болон ШГ-д хэрэгтэй эсэх	37
График 23 ОН-д чиглэсэн сургалтын үйл ажиллагаа явуулж, хянадаг эсэх	37
График 24 Зээлийн өргөдлийг үнэлж хянахад хялбар, ШГ-д хэрэгтэй эсэх	39
График 25 Зээлийн өргөдлийг үнэлж, хянадаг эсэх	39
График 26 БОЭ-г үнэлж, хянахад хялбар, шийдвэр гаргахад хэрэгтэй эсэх	41
График 27 БОЭ-г үнэлж, хянадаг эсэх	41
График 28 Ногоон зээлийн үлдэгдлийг хянахад хялбар, ШГ-д хэрэгтэй эсэх	43
График 29 Ногоон зээл олгож, хянадаг эсэх	43
График 30 БД-н бүтээгдэхүүн санал болгож, хянадаг эсэх	45
График 31 БД-н бүтээгдэхүүнээ хянахад хялбар, ШГ-д хэрэгтэй эсэх	46
График 32 Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн санал болгох төлөвлөгөө байгаа эсэх	49
График 33 Санал болгохоор төлөвлөж буй бүтээгдэхүүнүүд	49
График 34 Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн гаргахад тулгарч буй сорилтууд	50
График 35 Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн санал болгоход шаардлагатай дэмжлэг	50

Хүснэгт 1 ББСБ-уудын түүвэр	10
Хүснэгт 2 ББСБ-уудын байгаль орчны гүйцэтгэлийн ногоон индекс 2.0	13
Хүснэгт 3 Үнэлгээ	15
Хүснэгт 4 Судалгаанд хамрагдсан ББСБ-ын дундаж ногоон индекс	16
Хүснэгт 5 Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ - байршлаар	20
Хүснэгт 6 Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ - статусаар	21
Хүснэгт 7 Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ - хугацаагаар	22
Хүснэгт 8 Байгаль орчны стратегийг тодорхойлж, удирдаж, хянадаг байдлын дундаж үнэлгээ	24
Хүснэгт 9 Байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг байдал	26
Хүснэгт 10 Байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг байдал	28
Хүснэгт 11 Ногоон боломжийг дэмжиж, урамшуулдаг байдал	31
Хүснэгт 12 Экологийн дотоод ул мөрийн өөрчлөлт.	35
Хүснэгт 13 ОН-д чиглэсэн сургалтын үйл ажиллагаа явуулсан тоо, өсөлтийн хэмжээ	38
Хүснэгт 14 Зээлийн өргөдлийн тооны өөрчлөлт	34
Хүснэгт 15 БОЭ-тэй зээлийн үлдэгдлийн өөрчлөлт	42
Хүснэгт 16 Олгосон ногоон зээлийн хэмжээ, салбараар	44
Хүснэгт 17 БД-ын гэрээтэй зээлдэгчийн тоо, өөрчлөлт	46
Хүснэгт 18 БОГ-ийн тоон үзүүлэлтийн дүгнэлт	47



## ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажлыг Санхүүгийн Зохицуулах Хорооны захиалгаар, Alliance for Financial Inclusion (AFI)-ийн санхүүжилтээр Компанийн Засаглалын Хөгжлийн Төв, СЭЗИС-ийн багш нарын баг 2020 оны 6 дугаар сарын 02-оос 8 дугаар сарын 20-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Судалгааг 263 ББСБ-аас ногоон санхүүжилтийн өнөөгийн нөхцөл байдал, ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн зах зээл дээр гаргахад тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг тодорхойлох зорилгоор Бичил санхүүгийн байгууллагын ногоон санхүүжилтийн нөхцөл байдлыг тодорхойлох “Ногоон индекс 2.0” аргачлалыг ашиглан явуулсан.

Судалгааг КЗХТ-ийн судлаач, зөвлөхүүд болох Т.Цэнд-Аюуш, А.Одгэрэл, Б.Ариундалай нар хамтран гүйцэтгэсэн бөгөөд судлаачиддаа болон СЗХ-ны Гадаад Харилцаа хариуцсан дарга н.Эрдэнэбаатар, мэргэжилтэн М.Долгоржав, Ж.Агиймаа болон СЗХ-ны ББСБ-ийн газрын дарга Б.Итгэлсүрэн, ББСБ-н газрын референт Н.Баярсайхан, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын ахлах зөвлөх А.Баянмөнх, мэргэжилтэн нарт судалгааны ажлыг амжилттай явуулах нөхцлийг хангаж, дэмжин ажилласанд талархаж буйгаа илэрхийлье.

Компанийн Засаглалын Хөгжлийн Төв  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Т.ЦЭНД-АЮУШ (Ph.D)

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ББСБ –	Банк бус санхүүгийн байгууллага
БСБ –	Бичил санхүүгийн байгууллага
СЗХ –	Санхүүгийн зохицуулах хороо
БОГИ –	Байгаль орчны гүйцэтгэлийн индекс
ТоС –	Тогтвортой санхүү
ХК –	Хувьцаат компани
ХХК –	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## СУДАЛГААНЫ БАГ



**Түвшинтөрийн  
ЦЭНД-АЮУШ**

КЗХТ-ийн Гүйцэтгэх  
захирал  
СЭЗИС-ийн доктор,  
профессор



**Алтангэрэлийн ОДГЭРЭЛ**

КЗХТ-ийн судлаач, зөвлөх  
СЭЗИС-ийн ахлах багш



**Болдын АРИУНДАЛАЙ**

КЗХТ-ийн судлаач  
СЭЗИС-ийн дадлагажигч  
багш

## ОРШИЛ

Сүүлийн жилүүдэд хүн төрөлхтний дунд хамгийн их яригдаж буй сэдэв бол тогтвортой бөгөөд олон улс орны бодлого боловсруулагчид тогтвортой хөгжлийг нэн тэргүүний зорилго болгон “Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал”-г батлан хэрэгжүүлж байна. Манай улсын хувьд мөн адил 2016 онд “МУ-ын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал”-ыг баталсан бөгөөд Төрийн байгууллага, арилжааны банкууд, хувийн хэвшлийн төлөөллүүд хэлэлцэн МУ-н Тогтвортой Санхүүжилт (ТоС)-н хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Улмаар 2018 онд МУ-н Тогтвортой Санхүүжилтийн Үндэсний замын зургийг “Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ”, “Ногоон зээл”, “Тогтвортой санхүүжилтийг дэмжих хамтын ажиллагаа, бодлогын орчин” гэсэн 3 бүлэгтэй боловсруулж баталсан байдаг. 2015 оноос эхлэн арилжааны банкууд ТоС-ийн зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхэлсэн ба өнөөдрийн байдлаар МУ-н хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх банкууд ТоС-н зарчмуудыг хэрэгжүүлж, өөрсдийн үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгмийн удирдлагын системийг бүрдүүлэн, зээл санхүүжилт олгохдоо байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тооцоолон ажиллаж байна. Санхүүгийн Зохицуулах Хороо 2018 онд “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги төлөвлөгөө 2018-2021)-г батлуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд уг стратегийн онцлох чиглэл нь ногоон эдийн засгийг дэмжсэн байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүжилт юм.

Бичил санхүү гэдэг нь ердийн банк, санхүүгийн үйлчилгээг авч чадахгүй байгаа нийгмийн бага орлоготой иргэд, бизнес эрхлэгчдэд үзүүлж буй санхүүгийн үйлчилгээ юм. Бичил санхүүжилт нь 1970-аад онд Бангладешийн эрдэмтэн Мухамед Юнусын үндэслэсэн Грамеен банкнаас үүсэлтэй бөгөөд бичил санхүүгийн хөдөлгөөнийг үүсгэн байгуулагчид нь нийгмийн бага орлоготой хэсгийг чадавхжуулах, тодорхой боломжоор хангах чиглэлээр ажиллаж ирсэн байдаг (С.Дашдорж, 2019). Сүүлийн 10 жилд бичил санхүүгийн салбараас санхүүжилт авсан зээлдэгчдийн тоо 43 хувиар өссөн ба нийт 139.9 сая зээлдэгчдийн 80 хувь нь эмэгтэй, 65 хувь нь хөдөө орон нутгийн иргэд байна. Өмнөд Азийн улсууд болох Энэтхэг, Бангладеш, Вьетнам зэрэг улсууд бичил санхүүгийн салбарын үйлчилгээгээр тэргүүлж байна (СЗХ, 2019).

Сүүлийн жилүүдэд БСБ-ууд ядуурлыг бууруулах зорилгоос тогтвортой байдлыг хангах чиглэл рүү шилжиж эхэлсэн бөгөөд БСБ-ийн гол зорилго нь нийгмийн болон байгаль орчны хүчин зүйлүүдийг багтааж, тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хүчтэй арга хэрэгсэл

болохоо харуулж байна. Иймд тогтвортой бичил санхүүгийн үндсэн зорилго нь “эдийн засаг, нийгэм, байгаль орчин” гэсэн гурван тулгуурт зорилгуудад анхаарах болсон.



Эх сурвалж: *Greening the banking system 2015, UNEP Inquiry*

Ногоон санхүүжилт нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй, тогтвортой бизнесийн төслүүдэд хөрөнгө оруулах, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэж буй эрсдэлийг бууруулах, түүнээс сэргийлэх шинэлэг санаа бүхий инновацийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, байгаль орчинд ээлтэй бизнес, төслийг санхүүжүүлэхэд чухал хувь нэмэртэй юм. Өөрөөр хэлбэл ногоон санхүүжилт нь санхүүгийн зах зээлээр дамжуулан байгаль орчноо хамгаалах, тогтвортой хөгжлийг хангах чухал гарц болж байгаа юм.

Ногоон бичил санхүү нь дээрх гурван тулгуурт тогтвортой бичил санхүүгийн байгаль орчны зорилгыг хангахын тулд бага орлоготой иргэд, бизнес эрхлэгчдэд зээл олгох болон техникийн туслалцаа буюу “ногоон” байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, технологийг авахад нь дэмжлэг үзүүлэх зэргээр ажилладаг.

## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

### Судалгааны зорилго:

Энэхүү судалгааны хүрээнд ногоон санхүүжилт, байгаль орчны гүйцэтгэлийг хэмжих онол аргазүйг судлан, ногоон санхүүжилтийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгааны аргазүйг боловсруулж, МУ-н ББСБ-ийн ногоон санхүүжилтийн өнөөгийн нөхцөл байдал, ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн зах зээл дээр гаргахад тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг тодорхойлох, санал зөвлөмж боловсруулахыг зорилоо.

**Судалгааны зорилтууд:**

- Ногоон бичил санхүүгийн өнөөгийн байдлыг хэмжих онол арга зүйг судалж, судалгааны арга зүйг тодорхойлох;
- ББСБ-уудын байгаль орчны гүйцэтгэлийг үнэлж, санхүүжилтийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох;
- Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүнийг зах зээл дээр гаргахад тулгарч буй саад бэрхшээл, сорилтуудыг тодорхойлох;
- Судалгааны үр дүнд тулгуурлан дүгнэлт, санал зөвлөмж боловсруулах.

## СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ТҮҮВЭР

Судалгаанд зөвхөн Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудыг хамруулсан бөгөөд 2019 оны жилийн эцсийн байдлаар 538 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

*Хүснэгт 1 ББСБ-уудын түүвэр*

<b>2019 оны 12 сарын 31 ний байдлаар үйл ажиллагаа явуулж буй ББСБ</b>	<b>538</b>
<b>Үүнээс судалгааны түүвэрт хамруулаагүй ББСБ-н тоо:</b>	
Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн	3
Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	14
Зээлийн үйл ажиллагаа явуулдаггүй	45
2020 онд тусгай зөвшөөрлийг сэргээсэн	1
2019 онд шинээр байгуулагдсан	14
<b>Нийт судалгаанд хамрагдах боломжтой ББСБ</b>	<b>431</b>

Судалгаанд хамрагдах боломжтой 461 ББСБ-аас судалгааны итгэх түвшин 95 хувь, алдааны хязгаар +/-5 хувь, судалгаанд оролцогчоос хариулт авах магадлал 70 хувь байхаар 300 ББСБ-г хамруулж, судалгааны асуулгыг цахимаар илгээсэн. Судалгааны түүвэрт хамрагдсан байгууллагуудаас судалгааны асуулгыг 2019 оны 7 р сарын 27 ноос 31 ний хооронд цахимаар цуглуулсан ба нийт 263 буюу 87.7 хувь нь судалгааны асуулгад хариу өгсөн байна.

## СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Бичил санхүүгийн байгууллагын ногоон санхүүжилтийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох хэд хэдэн аргачлал байдаг хэдий ч “Ногоон индекс 2.0” аргачлал нь бичил санхүүгийн байгууллагуудын байгаль орчны оролцоо болон гүйцэтгэлийг үнэлж, хэмждэг хамгийн түгээмэл, хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал юм. Энэхүү аргачлалын эхний хувилбар болох “Ногоон индекс 1.0” –ийг Европын холбооны Бичил санхүүгийн платформы ажлын хэсэг<sup>1</sup> (58 гишүүн орны 41 байгууллагыг багтаасан) бичил санхүүгийн байгууллагуудын байгаль орчны хариуцлагыг бэхжүүлэх зорилгоор 2014 онд боловсруулсан байна. Уг аргаар 2014-2016 онд SPI4 CERISE, MIX Market болон ажлын хэсгийн түншүүдтэй хамтран 6 улсын 31 байгууллагад туршилтын үнэлгээг хийсэн байна. Улмаар 2016 оны 8 сард “Ногоон индекс 2.0” буюу хоёр дах хувилбарыг нийтэд танилцуулсан.

“Ногоон индекс 2.0” аргачлал нь бичил санхүүгийн байгууллагуудын байгаль орчны гүйцэтгэлийн өнөөгийн байдал, хэрэгжүүлж буй бодлого, үйл явц, ногоон бүтээгдэхүүн үйлчилгээ, болон байгаль орчны асуудлыг хэрхэн тайлагнадаг талаар үнэлэх боломжтой бөгөөд чанарын болон тоон гэсэн хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй (group, 2016). Тус аргачлалын чанарын индекс нь 4 стандарт, 16 үзүүлэлтээс бүрддэг.

Энэхүү индекс нь үндсэн дөрвөн стандарттай. Үүнд:

**Стандарт 1:** ББСБ-ын байгаль орчны стратегийн талаар буюу тодорхой бодлого байгаа эсэх, байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцсан ажилтан байгаа эсэх, байгаль орчны гүйцэтгэлээ тайлагнадаг эсэх;

**Стандарт 2:** Байгаль орчны дотоод эрсдэлийг удирдах аргуудын талаар буюу байгаль орчны экологийн ул мөрийг жишээлбэл цаас, эрчим хүч хэмнэх зэргийг төв болон салбарын түвшинд хянаж, удирддаг эсэх;

**Стандарт 3:** Энэ нь байгаль орчны гадаад эрсдэлийн удирдлагыг авч үздэг. ББСБ-ууд нь санхүүжүүлэх үйл ажиллагааны байгаль орчинтой холбоотой эрсдэлийг үнэлж, зээл олгох эсэх шийдвэрийн шалгуур болгон ашигладаг, өндөр эрсдэлтэй тохиолдолд эрсдэлийг бууруулах талаар зээлдэгчийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авдаг эсэх;

<sup>1</sup> E-MFP Action group

**Стандарт 4:** БСБ-ууд хэрхэн ногоон боломжуудыг дэмжих талаар буюу санал болгож буй, жишээлбэл сэргээгдэх эрчим хүч, тогтвортой хөдөө аж ахуй, байгаль орчинд ээлтэй бизнес, байгаль орчны өөрчлөлттэй холбоотойгоор өөрсдийн харилцагчдын уян хатан байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн онцлог санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээнүүд санал болгодог эсэх.

Энэхүү индекс нь бичил санхүүгийн хүрээнд байгаль орчны үүрэг хариуцлага болон байгаль орчны менежментийг дэмжих, мөн хүртээмжтэй санхүүгийн секторыг дэмжих үндсэн хэрэгсэл болох ба ялангуяа ногоон индексийг тодорхойлсноор ББСБ-ууд, хөрөнгө оруулагчид, бичил санхүүгийн зэрэглэл тогтоох байгууллага болон мэргэжлийн холбоод, байгууллагуудын хувьд чухал ач холбогдолтой юм.

БСБ-ууд, болон бусад санхүүгийн байгууллагуудын хувьд (удирдлага, ажилтан):

- Байгаль орчны одоогийн нөхцөл байдлыг үнэлэх;
- Байгаль орчны өөрийн нөхцөл байдлыг бусад байгууллагуудтай харьцуулах;
- Байгаль орчинтой холбоотой өөрсдийн стратегиа тодорхойлох;
- Цаг хугацааны туршид байгаль орчны гүйцэтгэлийн ахиц дэвшлийг хянах;
- Байгаль орчны гүйцэтгэлийн талаар харилцах зэрэгт хэрэгтэй.

Хөрөнгө оруулагч болон бичил санхүүгийн зэрэглэл тогтоох байгууллагуудын хувьд:

- БСБ-уудын байгаль орчны гүйцэтгэлийн талаар ойлголт олж авах;
- Хөрөнгө оруулалт хийх зорилготой байгууллага болон бүх БСБ-уудын хувьд нийтлэг тайлагналын хэрэгсэлтэй болох ба улмаар бэнчмарк хийх, ахиц дэвшлийг үнэлж хянах боломжтой болно.

Мэргэжлийн байгууллага, холбоод болон техник тусалцааны байгууллагуудын хувьд:

- БСБ-уудын байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулахын тулд зөрүүг тодорхойлох, шаардлагатай дэмжих үйлчилгээг хөгжүүлэх;

- Тэдний дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нь ББСБ-ууд эсвэл бусад санхүүгийн байгууллагуудын байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулахад хэрхэн тусалж байгааг үнэлэхэд хэрэгтэй.

Иймд Монгол улсын ББСБ-уудын хувьд ногоон санхүүжилтийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгааг хийхдээ 4 стандарт, чанарын болон тоон 21 үзүүлэлт бүхий “Ногоон индекс 2.0” аргачлалыг ашигласан болно.

Хүснэгт 2 ББСБ-уудын байгаль орчны гүйцэтгэлийн ногоон индекс 2.0

	Ногоон бичил санхүү (чанарын үзүүлэлт)	(Тийм, Үгүй, Хэсэгчлэн)
<b>Стандарт 1</b>	<b>Байгаль орчны стратегийг тодорхойлж, удирдаж, хянадаг эсэх</b>	
<b>Үндсэн практик</b>	<b>Тухайн байгууллага байгаль орчны стратегиа тодорхойлсон эсэх</b>	
Үзүүлэлт	Тухайн байгууллага өөрийн эрхэм зорилго болон үнэт зүйлдээ байгаль орчныг хамгаалах талаар тусгадаг эсэх	
Үзүүлэлт	Тухайн байгууллага нь өөрийн байгаль орчны талаар баримтлах зорилго, зорилт болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээ (indicators) тодорхойлж тусгасан байгаль орчны талаарх албан ёсны бодлоготой эсэх	
<b>Үндсэн практик</b>	<b>Тухайн байгууллага байгаль орчны стратегиа удирдаж, хянадаг эсэх</b>	
Үзүүлэлт	Тухайн байгууллага нь хүрээлэн буй орчны асуудлыг хариуцсан хороо эсвэл ажилтныг томилдог эсэх	
Үзүүлэлт	Тухайн байгууллага байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээ дотоод тайлангууд (ТУЗ, хөрөнгө оруулагчдад)-д тайлагнадаг эсэх	
Үзүүлэлт	Тухайн байгууллага байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээ гадаад тайлангууд (олон нийтэд зориулан гаргадаг жилийн тайлангууд)-д тайлагнадаг эсэх	
<b>Стандарт 2</b>	<b>Байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг эсэх</b>	
<b>Үндсэн практик</b>	<b>Тухайн байгууллага нь байгаль орчны дотоод ул мөрийг багасгах ажиллагааг хийдэг эсэх</b>	
<b>Үзүүлэлт</b>	Тухайн байгууллага нь төв болон салбарууддаа сэргээгдэх эрчим хүч ашиглах, хог хаягдлыг дахин боловсруулах /эсвэл эрчим хүч, ус, цаас, түлшний хэрэглээг бууруулах, хог хаягдлыг багасгах/ эсвэл хүлэмжийн хийг багасгах 2 буюу түүнээс дээш ажлуудыг хэрэгжүүлдэг эсэх	
<b>Үндсэн практик</b>	<b>Тухайн байгууллага нь дотоод экологийн ул мөрийг хянадаг эсэх</b>	

Үзүүлэлт	Төв болон салбар нэгжүүддээ эрчим хүч, ус, цаас, түлшний хэрэглээ болон хог хаягдал, хүлэмжийн хийг багасгахаар тогтоосон 2 буюу түүнээс дээш тоон зорилтдоо хүрч буй эсэхээ хянадаг эсэх	
<b>Стандарт 3.</b>	<b>Байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг эсэх</b>	
Үндсэн практик	<b>Тухайн байгууллага нь харилцагчийн байгаль орчны эрсдэлийг үнэлдэг эсэх</b>	
Үзүүлэлт	Тухайн байгууллага харилцагчийн үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчны эрсдэлийг үнэлэх тусгай арга хэрэгсэл ашигладаг эсэх	
Үзүүлэлт	Тухайн байгууллага харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны эрсдэлийг хэрхэн үнэлэх талаар зээлийн ажилтнаа сургадаг эсэх	
Үндсэн практик	<b>Тухайн байгууллага харилцагчийн байгаль орчны эрсдэлийн түвшинг үнэлэх хүчин зүйлийг зээлийн бодлого, журамдаа оруулсан эсэх</b>	
Үзүүлэлт	Тухайн байгууллага зээлийн өргөдлийг байгаль орчны эрсдэлийн түвшингээр ангилж, эрсдэлийн ангилал тус бүрийн дагуу тусгай процедур хэрэгжүүлдэг эсэх	
Үндсэн практик	<b>Тухайн байгууллага байгаль орчны эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг дэмждэг эсэх</b>	
Үзүүлэлт	Тухайн байгууллага харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны эрсдэл болон түүнийг бууруулах стратегийн талаар таниулах үйл ажиллагаа зохион байгуулдаг эсэх	
<b>Стандарт 4.</b>	<b>Ногоон боломжийг дэмжиж, урамшуулдаг эсэх</b>	
Үндсэн практик	<b>Тухайн байгууллага байгаль орчинд ээлтэй цэвэр эрчим хүчинд (clean energy) зориулсан тусгай санхүүгийн бүтээгдэхүүн санал болгодог эсэх</b>	
Үзүүлэлт	Тухайн байгууллага сэргээгдэх эрчим хүч эсвэл эрчим хүчний хэмнэлтэд зориулсан тусгай зээлийн бүтээгдэхүүнийг санал болгодог эсэх	
Үндсэн практик	<b>Тухайн байгууллага тогтвортой эсвэл байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуйд зориулсан тусгай санхүүгийн бүтээгдэхүүн санал болгодог эсэх</b>	
Үзүүлэлт	Тухайн байгууллага тогтвортой эсвэл байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуйг (Climate-smart agriculture) дэмжих тусгай зээлийн эсвэл бусад санхүүгийн үйлчилгээ санал болгодог эсэх	
Үндсэн практик	<b>Тухайн байгууллага бусад ногоон санхүүгийн эсвэл санхүүгийн бус бүтээгдэхүүн санал болгодог эсэх</b>	
Үзүүлэлт	Тухайн байгууллага байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжихэд (сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, дахин боловсруулалт, хог хаягдлын менежмент, цэвэр ус гэх мэт) зориулсан зээлийн бүтээгдэхүүн санал болгодог эсэх	

Үзүүлэлт	Тухайн байгууллага харилцагчдадаа байгаль орчны эрсдэлээс хамгаалах зорилго бүхий бичил даатгалын бүтээгдэхүүнийг шууд эсвэл гуравдагч талтай хамтран санал болгодог эсэх	
Үзүүлэлт	Тухайн байгууллага харилцагчиддаа өөрөө шууд эсвэл байгаль орчны байгууллагатай хамтрах замаар хэрхэн байгаль орчинд ээлтэй бизнес эрхлэх чиглэлээр сургалт явуулдаг эсэх	

Эх сурвалж: E-MFP Microfinance and Environment Action Group Green Index 2.0, 2016

Судалгаанд чанарын үзүүлэлтүүдийг үнэлэхдээ “Тийм” бол 1 оноо, “Үгүй” бол 0 оноо, “Хэсэгчлэн хэрэгжүүлдэг” бол 0,5 оноогоор үнэлсэн ба ногоон индексийн нэгдсэн болон стандарт тус бүрийн үнэлгээг дараах байдлаар хувиар гаргасан болно.

Хүснэгт 3 Үнэлгээ

Ногоон дундаж индекс	Үнэлгээ
0-19 хувь	Сул
20-39 хувь	Дунд
40-59 хувь	Хангалттай
60-79 хувь	Сайн
80-100 хувь	Маш сайн

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд 461 ББСБ-аас хамрагдах боломжтойгоос 45-аас дээш зээлдэгчтэй 300 байгууллагыг хамруулж, судалгааны асуулгыг цахим шуудангаар илгээсэн ба үүнээс 263 байгууллага асуулгад хариу илгээсэн. Иймд судалгааны үр дүнг 263 байгууллагын хувьд нэгтгэн гаргалаа.

### 8.1. СУДАЛГААНЫ ТҮҮВРИЙН БҮТЭЦ

Судалгааны түүврийн бүтцийг хуулийн этгээдийн хэлбэр, байршил, үйл ажиллагаа явуулж буй хугацаа болон зээлдэгчийн тоогоор харуулбал дараах байдалтай байна.



График 1 Хуулийн этгээдийн хэлбэрээр



График 2 Хуулийн этгээдийн байршлаар



График 3 Үйл ажиллагаа явуулж буй жилээр





График 4 Судалгаанд оролцогч зээлдэгчийн тоогоор



Судалгаанд хамрагдсан 263 ББСБ-уудын 99 хувь нь ХХК, 86 хувь нь УБ хотод үйл ажиллагаа явуулдаг, 79 хувь нь 10-аас доош жил үйл ажиллагаа явуулж буй бөгөөд 200 хүртэл зээлдэгчтэй байгууллагууд байна.

## 8.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### 8.2.1. НОГООН ИНДЕКС 2.0 – НЭГДСЭН ДҮН

Судалгаанд хамрагдсан 263 ББСБ-ын хувьд “Ногоон индекс 2.0” аргачлалын дагуу байгаль орчны гүйцэтгэлийн ногоон индексийг 1) Байгаль орчны стратегийг тодорхойлж, удирддаг байдал, 2) Байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг байдал, 3) Байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг байдал, 4) Ногоон боломжийг дэмжиж урамшуулдаг байдал гэсэн 4 стандарт, 16 үзүүлэлт тус бүрээрх өөрийн үнэлгээнд тулгуурлан шинжилгээ хийлээ.


Судалгаанд оролцогчийн чанарын үзүүлэлт тус бүрээр өгсөн “Тийм, Үгүй, Хэсэгчлэн хэрэгжүүлдэг” гэсэн хариултуудыг 0-1 оноогоор үнэлж, үнэлгээний нэгдсэн үр дүнг оноогоор болон хувиар илэрхийллээ. Хүснэгт 4-д үзүүлсэн үнэлгээнээс харахад байгаль орчны гүйцэтгэлийн дундаж ногоон индекс **0.146 оноо** буюу **14.6 хувиар** үнэлэгдсэн байна.

Хүснэгт 4 Судалгаанд хамрагдсан ББСБ-ын дундаж ногоон индекс

Дугаар	Стандарт	Үнэлгээ	
		Оноогоор	Хувиар
1	Байгаль орчны стратегийг тодорхойлж, удирдаж, хянадаг эсэх	0.138	13.8%
2	Байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг эсэх	0.212	21.2%
3	Байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг эсэх	0.108	10.8%
4	Ногоон боломжийг дэмжиж, урамшуулдаг эсэх	0.126	12.6%
	<b>Дундаж ногоон индекс</b>	<b>0.146</b>	<b>14.6%</b>

Дээрх судалгааны үр дүнг SPI4-н ногоон индекстэй харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

График 5 МУ-н ББСБ-н ногоон индекс ба SPI4-ийн ногоон индексийн харьцуулалт



CERISE байгууллага нь олон нийтэд танигдсан нийгмийн гүйцэтгэлийн аудитын “SPI4” хэрэгсэлдээ байгаль орчны гүйцэтгэлийн “Ногоон индекс 1.0”-ийг нэмэлт үнэлгээний модуль болгон 2014 онд нэгтгэсэн. Тус байгууллага нь уг аргачлалын дагуу 2015 оны 11 сард 6 улсын 31 ББСБ-ыг хамруулж, байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээг хийсэн бөгөөд дундаж ногоон индекс нь **29 хувь** гарсан байна. Гэтэл бидний судалгаанд хамрагдсан ББСБ-уудын байгаль орчны гүйцэтгэлийн ногоон индекс нь SPI4-ийн судалгааны үр дүнтэй харьцуулахад даруй 14 пунктээр доогуур байна.

Олон улсын түвшинд 2011 оноос хойш БСБ-ын байгаль орчны гүйцэтгэлийн индексийг дараах судлаачид хэмжсэн байна.

- Судлаач M.Allet болон M.Hudon нар 2011 онд хөгжиж буй 5 улсын 160 БСБ-ыг хамруулан БСББОГИ (MEPI)-ийг хэмжсэн бөгөөд дундаж үнэлгээ нь 21 хувь байсан (Allet, 2015) .
- Судлаач D.Forcella 2013 онд Европын 36 улсын 59 БСБ-ыг хамруулж БСББОГИ (MEPI)-ийг хэмжсэн ба дундаж үнэлгээ нь 21 хувь гарсан (Forcella, 2013).
- ADA байгууллага 2014 онд 36 байгууллагыг хамруулан БСББОГИ (MEPI)-ийг хэмжсэн ба дундаж үнэлгээ нь 32 хувь гарсан (Passerelles, 2014).

Дээрх судлаачдын судалгааны үр дүнг судалгаанд хамрагдсан 263 ББСБ-ын байгаль орчны гүйцэтгэлийн ногоон индекстэй харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

График 6 Байгаль орчны гүйцэтгэлийн индексийн харьцуулалт




Дээрх графикаас харахад судалгаанд хамрагдсан 263 ББСБ-ын хувьд байгаль орчны гүйцэтгэлийн индекс нь хөгжиж буй улс орнууд, Европ болон Төв Америкт хийгдсэн судалгааны үр дүнгээс доогуур байгаа нь манай улсын хувьд ББСБ-уудын байгаль орчны стратегия тодорхойлж, удирддаг байдал, байгаль орчны эрсдэлийн удирдлага, ногоон боломжийг дэмжиж урамшуулах байдал сул байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл ногоон бичил санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал

бусад улс орнуудтай харьцуулахад тааруу байдал ажиглагдаж байна.

Мөн судалгаанд хамрагдсан ББСБ-уудын 71 хувь нь 20 хувиас бага үнэлгээтэй, 19 хувь нь 20 оос 40 хувийн үнэлгээтэй, харин 10 хувь нь 40-өөс дээш хувийн үнэлгээтэй байна. Судалгааны үр дүнг графикаар харуулбал:


График 7 Ногоон индексийн үнэлгээ - ББСБ-ийн хувиар



Дээрх графикаас харахад судалгаанд хамрагдсан ББСБ-уудын дийлэнх буюу 71 хувь нь 20 хувиас бага байгаль орчны гүйцэтгэлийн индексстэй байгаа нь маш хангалтгүй байна.

Судалгаанд хамрагдсан ББСБ-уудын хувьд байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээг стандарт тус бүрээр графикаар харуулбал дараах байдалтай байна.

График 8 Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ - стандарт тус бүрээр



Дээрх графикаас харахад байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг байдал 21.2 хувь буюу дунд зэрэг үнэлэгдсэн нь судалгаанд хамрагдсан байгууллагууд ямар нэг байдлаар байгаль орчны дотоод

экологийн ул мөрийг багасгах ажил хийдэг, түүний үр дүнг хянадаг болох нь харагдаж байна.

Харин байгаль орчны гадаад эрсдэлийн удирдлага хамгийн бага буюу 10.8 хувь, ногоон боломжийг дэмжиж урамшуулдаг байдал нь 12.6 хувь, байгаль орчны стратегийг тодорхойлж, удирдаж буй байдал нь 13.8 хувиар үнэлэгдсэн нь хангалтгүй байна. Өөрөөр хэлбэл байгаль орчны стратегиа тодорхойлж, гүйцэтгэлийг хэмжих байдал, мөн байгаль орчны гадаад эрсдэлийг үнэлж, хянах болон ногоон боломжийг дэмжих байдал сул байна гэж үзэж байна.

БСБ-ын байгаль орчны гүйцэтгэлд тухайн байгууллагын хэмжээ, байршил, үйл ажиллагаа явуулж буй хугацаа, хэлбэр нөлөө үзүүлдэг эсэхийг 160 БСБ-ыг хамруулан судалсан (Allet, 2015). Түүний судалгаа үйл ажиллагаа явуулж буй хугацаа урт, харилцагчийн тоо их, байгууллагын хэлбэр нээлттэй байх тусам байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ нь өндөр байдгийг баталсан байна.

- **Байршил**

Судалгаанд хамрагдсан 263 ББСБ-ын 86 хувь нь УБ хотод үйл ажиллагаа явуулдаг бол үлдсэн нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг байна. Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээг байршлаар нь гаргавал дараах байдалтай байна.


Хүснэгт 5 Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ - байршлаар

Дугаар	Стандарт	Үнэлгээ	
		УБ хот	Орон нутаг
1	Байгаль орчны стратегийг тодорхойлж, удирдаж, хянадаг эсэх	14.7%	8.4%
2	Байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг эсэх	22.2%	15.5%
3	Байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг эсэх	11.3%	6.7%
4	Ногоон боломжийг дэмжиж, урамшуулдаг эсэх	13.1%	10.2%
	<b>Дундаж ногоон индекс</b>	<b>15.3%</b>	<b>10.2%</b>

Судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг ББСБ-уудын байгаль орчны гүйцэтгэлийн ногоон индекс 15.3 хувь буюу хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудтай харьцуулахад бүх стандартын хувьд өндөр байна.

Харин хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ББСБ-уудын хувьд байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг байдал нь 6.7 хувь, байгаль орчны стратегийг тодорхойлж удирддаг байдал нь 8.4 хувь байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт байна. Энэхүү үр дүнг графикаар харуулбал дараах байдалтай байна.

График 9 Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ - ББСБ-н бүс нутгаар



• **Хуулийн этгээдийн хэлбэр**

Судалгаанд хамрагдсан 263 ББСБ-ын 99 хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай компани бол үлдсэн 1 хувь нь МУ-н хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.


Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээг статусаар нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 6 Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ - статусаар

Дугаар	Стандарт	Үнэлгээ	
		ХХК	ХК
1	Байгаль орчны стратегийг тодорхойлж, удирдаж, хянадаг эсэх	13.9%	6.7%
2	Байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг эсэх	21.1%	33.3%
3	Байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг эсэх	10.8%	4.1%
4	Ногоон боломжийг дэмжиж, урамшуулдаг эсэх	12.5%	20.0%
	<b>Дундаж ногоон индекс</b>	<b>14.6%</b>	<b>16.04%</b>

Дээрх хүснэгтээс харвал нээлттэй хувьцаат компаниудын хувьд ногоон индекс нь өндөр байна. Ялангуяа байгаль орчны дотоод эрсдэлийн удирдлага, ногоон боломжийг дэмжиж урамшуулдаг байдал нь хязгаарлагдмал хариуцлагатай компаниудтай харьцуулахад сайн байна. Харин бусад үзүүлэлтүүд нь доогуур үнэлэгдсэн байна.

График 10 Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ статусаар



• **Үйл ажиллагаа явуулж буй хугацаа**

Судалгаанд хамрагдсан 263 ББСБ-ын 79 хувь нь 10-аас доош жил үйл ажиллагаа явуулж байгаа бол үлдсэн нь 10 ба түүнээс дээш жил үйл ажиллагаа явуулж байна.

Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээг үйл ажиллагаа явуулж буй хугацаанаас нь хамааруулж харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 7 Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ - хугацаагаар

Дугаар	Стандарт	Үнэлгээ			
		5 хүртэл жил	5-10 жил	10-15 жил	15-аас дээш жил
1	Байгаль орчны стратегийг тодорхойлж, удирдаж, хянадаг эсэх	14.9%	11.1%	13.5%	20.0%
2	Байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг эсэх	20.2%	21.1%	20.5%	28.7%
3	Байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг эсэх	11.6%	8.6%	10.6%	15.0%
4	Ногоон боломжийг дэмжиж, урамшуулдаг эсэх	13.4%	10.6%	12.3%	18.0%
	<b>Дундаж ногоон индекс</b>	<b>15.1%</b>	<b>12.8%</b>	<b>14.3%</b>	<b>20.4%</b>

Дээрхээс 15-аас дээш жил үйл явуулж буй ББСБ-уудын байгаль орчны ногоон индекс нь 20.4 хувь гарсан нь дунд зэрэг үнэлэгдсэн байгаа нь бусад байгууллагатай харьцуулахад байгаль орчны асуудалд тодорхой хэмжээнд анхаарч үздэг байдал ажиглагдаж байна. Энэхүү үр дүнг графикаар харуулбал дараах байдалтай байна.

График 11 Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ - хугацаагаар



Дээрх графикаас 15-аас дээш жил үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудын хувьд байгаль орчны гүйцэтгэлийн бүх стандартын хувьд харьцангуй өндөр байгаа нь ажиглагдлаа. Харин 0-15 хүртэл жил үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудын хувьд дээрх үзүүлэлтүүд ойролцоо ба 15-аас дээш жил үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай харьцуулахад тааруухан гүйцэтгэлтэй байна.

### 8.2.2. НОГООН ИНДЕКС 2.0 – СТАНДАРТ 1 БАЙГАЛЬ ОРЧНЫ СТРАТЕГИЙГ ТОДОРХОЙЛЖ, УДИРДАЖ, ХЯНАДАГ БАЙДАЛ

Стандарт 1 нь бичил санхүүгийн байгууллагын албан ёсны байгаль орчны стратегийн бодлого, байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцсан ажилтан эсвэл хороо болон байгаль орчны гүйцэтгэлийг тайлагнахтай холбоотой үзүүлэлтүүдийг багтаасан байдаг. Энэхүү стандартын үзүүлэлт тус бүрээр дундаж үнэлгээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8 Байгаль орчны стратегийг тодорхойлж, удирдаж, хянадаг байдлын дундаж үнэлгээ

Стандарт 1	Байгаль орчны стратегийг тодорхойлж, удирдаж, хянадаг эсэх	Дундаж хувь
<b>Үндсэн практик</b>	<b>Тухайн байгууллага байгаль орчны стратегиа тодорхойлсон эсэх</b>	<b>21.8%</b>
Үзүүлэлт	Тухайн байгууллага өөрийн эрхэм зорилго болон үнэт зүйлдээ байгаль орчныг хамгаалах талаар тусгадаг эсэх	34.2%
Үзүүлэлт	Тухайн байгууллага нь өөрийн байгаль орчны талаар баримтлах зорилго, зорилт болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээ (indicators) тодорхойлж тусгасан байгаль орчны талаарх албан ёсны бодлоготой эсэх	9.3%
<b>Үндсэн практик</b>	<b>Тухайн байгууллага байгаль орчны стратегиа удирдаж, хянадаг эсэх</b>	<b>8.6%</b>
Үзүүлэлт	Тухайн байгууллага нь хүрээлэн буй орчны асуудлыг хариуцсан хороо эсвэл ажилтныг томилдог эсэх	9.1%
Үзүүлэлт	Тухайн байгууллага байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээ дотоод тайлангууд (ТУЗ, хөрөнгө оруулагчдад)-д тайлагнадаг эсэх	9.7%
Үзүүлэлт	Тухайн байгууллага байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээ гадаад тайлангууд (олон нийтэд зориулан гаргадаг жилийн тайлангууд)-д тайлагнадаг эсэх	6.8%
	<b>Нийт дундаж үнэлгээ</b>	<b>13.8%</b>

Дээрх хүснэгтээс үзвэл судалгаанд хамрагдсан ББСБ-уудын хувьд тус стандартын дундаж үнэлгээ **13.8 хувь** буюу хангалтгүй үнэлгээтэй байна. Хэдийгээр судалгаанд хамрагдсан байгууллагууд ямар нэг байдлаар эрхэм зорилго, үнэт зүйлээ тодорхойлохдоо байгаль орчны асуудлыг тусгадаг боловч түүний гүйцэтгэлийг хэмжиж үнэлэх болон тайлагнах байдал нь хангалтгүй байна.


График 12 Стандарт 1-ийн үзүүлэлт тус бүрийн дундаж үнэлгээ



Стандарт 1-ийн үзүүлэлтүүдээс тухайн байгууллага эрхэм зорилго, үнэт зүйлдээ байгаль орчныг хамгаалах талаар тусгадаг байдал 34.2 хувь буюу хамгийн өндөр байгаа бол бусад 4 үзүүлэлт нь 20 хувиас бага буюу маш хангалтгүй гүйцэтгэлтэй байна. Ялангуяа тухайн байгууллага нь байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээ гадаад тайлан буюу олон нийтэд зориулсан жилийн тайландаа тайлагнадаг байдал хамгийн бага, 6.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь ББСБ-уудын хувьд байгаль орчны талаар баримтлах албан ёсны бодлого байхгүй, улмаар байгаль орчны асуудал хариуцсан ажилтан эсвэл хорооны томилгоо хангалтгүй байгааг илтгэж байна. Мөн байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтээ гадаад болон дотоод мэдээлэл хэрэглэгч, оролцогч талуудад тайлагнадаг байдал сул байгаа нь ББСБ-уудын засаглал, мэдээллийн ил тод, нээлттэй байдал сул байгаатай холбоотой байж болох талтай.

Байгаль орчны гүйцэтгэлийн ногоон индексийн стандарт 1-ийг хэрэгжүүлдэг эсэхийг судалгаанд хамрагдсан 263 ББСБ-уудын хувьд үзүүлэлт тус бүрээр нэгтгэн доорх графикаар харуулсан.

График 13 Судалгаанд оролцогчдын байгаль орчны стратегийг тодорхойлж, удирддаг байдал



Судалгаанд оролцогчдын 16 хувь нь байгаль орчны асуудлыг эрхэм зорилго, үнэт зүйлдээ тусгадаг бол, 48 хувь нь огт тусгадаггүй байна. Мөн 15 хувь нь ямар нэг байдлаар байгаль орчны тухайд баримтлах бодлоготой бол үлдсэн 85 хувь нь байгаль орчны талаар баримтлах албан ёсны бодлого байхгүй гэж хариулсан байна. Нийт судалгаанд оролцогчдын 13 хувь нь байгаль орчны асуудал хариуцсан ажилтан болон хороо дотооддоо томилдог бол үлдсэн хувь нь байгаль орчны асуудал хариуцсан ажилтан тусгайлан томилдоггүй байна.

Мөн судалгаанд оролцогчдын 14 хувь нь ямар нэг байдлаар байгаль орчны гүйцэтгэлээ ТУЗ, удирдлагуудад тайлагнадаг бол 86 хувь нь огт тайлагнадаггүй гэж хариулсан байна. Харин судалгаанд оролцогчдын 9 хувь нь тодорхой хэмжээнд байгаль орчны гүйцэтгэлээ гадаад оролцогч талуудад тайлагнадаг бол 90 хувь нь огт тайлагнадаггүй гэж хариулсан байна.

Судалгаанд оролцогчдын 20 орчим хувь нь тус стандартын шаардлагуудыг хэрэгжүүлдэг, дийлэнх буюу 80 орчим хувь нь хэрэгжүүлдэггүй гэж хариулсанаас үзвэл байгууллагуудын байгаль орчны стратегийг тодорхойлж удирддаг байдал нь маш хангалтгүй байна.

### 8.2.3. НОГООН ИНДЕКС 2.0 – СТАНДАРТ 2 БАЙГАЛЬ ОРЧНЫ ДОТООД ЭРСДЭЛИЙГ УДИРДДАГ БАЙДАЛ


Энэхүү стандарт нь байгаль орчны дотоод эрсдэлийг удирдах аргуудын талаар буюу байгаль орчны экологийн дотоод ул мөр болох цаас, эрчим хүч хэмнэх зэргийг төв болон салбарын түвшинд хянах, удирдахтай холбоотой үзүүлэлтүүдийг багтаасан байдаг. Энэхүү стандартын үзүүлэлт тус бүрээр дундаж үнэлгээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 9 Байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг байдал

Стандарт 2	Байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг эсэх	Дундаж хувь
<b>Үндсэн практик</b>	<b>Тухайн байгууллага нь байгаль орчны дотоод ул мөрийг багасгах ажиллагааг хийдэг эсэх</b>	<b>23.4%</b>
Үзүүлэлт	Тухайн байгууллага нь төв болон салбарууддаа сэргээгдэх эрчим хүч ашиглах, хог хаягдлыг дахин боловсруулах /эсвэл эрчим хүч, ус, цаас, түлшний хэрэглээг бууруулах, хог хаягдлыг багасгах/ эсвэл хүлэмжийн хийг багасгах 2 буюу түүнээс дээш ажлуудыг хэрэгжүүлдэг эсэх	23.4%
<b>Үндсэн практик</b>	<b>Тухайн байгууллага нь дотоод экологийн ул мөрийг хянадаг эсэх</b>	<b>19.9%</b>
Үзүүлэлт	Төв болон салбар нэгжүүддээ эрчим хүч, ус, цаас, түлшний хэрэглээ болон хог хаягдал, хүлэмжийн хийг багасгахаар тогтоосон 2 буюу түүнээс дээш тоон зорилтдоо хүрч буй эсэхээ хянадаг эсэх	19.0%
	<b>Нийт дундаж үнэлгээ</b>	<b>21.2%</b>

Дээрх хүснэгтээс харвал судалгаанд хамрагдсан ББСБ-уудын хувьд стандарт 2-ын дундаж үнэлгээ 21.2 хувь буюу дундаж үзүүлэлттэй байна. Тус үзүүлэлтүүдийг графикаар харуулбал дараах байдалтай байна.


График 14 Стандарт 2-ын гүйцэтгэлийн үзүүлэлт тус бүрийн дундаж үнэлгээ



Тус стандартын үзүүлэлт тус бүрийг авч үзвэл ББСБ-ууд дотоод экологийн ул мөрийг багасгах ажлуудыг хийдэг байдал 23.4 хувь буюу дундаж үнэлгээтэй байгаа нь ямар нэг байдлаар цаас, шатахуун, түлшний хэрэглээг дотооддоо бууруулах ажил хийдэг байна. Гэвч цаас, шатахуун, ус, түлшний хэрэглээг бууруулах ажлын гүйцэтгэлийг хянадаг байдал 19 хувь буюу хангалтгүй үнэлэгдсэн байна.

Байгаль орчны гүйцэтгэлийн ногоон индексийн стандарт 2-ийг хэрэгжүүлдэг эсэхийг судалгаанд хамрагдсан 263 ББСБ-уудын хувьд үзүүлэлт тус бүрээр нэгтгэн доорх графикаар харуулсан.

График 15 Судалгаанд оролцогчдын байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг байдал



Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 35 хувь нь тодорхой хэмжээнд байгаль орчны дотоод экологийн ул мөрийг багасгах ажил хийдэг бол дийлэнх нь буюу 65 хувь нь дотоод экологийн ул мөрийг багасгахад огт анхаарал хандуулдаггүй гэж хариулсан байна.

Мөн судалгаанд хамрагдсан байгууллагуудын 28 хувь нь ямар нэг

байдлаар байгаль орчны дотоод экологийн ул мөрийг багасгах ажиллагааг хянадаг бол дийлэнх нь буюу 73 хувь нь тус үйл ажиллагаанд хяналт тавьдаггүй гэж хариулсан байна.

#### 8.2.4. НОГООН ИНДЕКС 2.0 – СТАНДАРТ 3 БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАДААД ЭРСДЭЛИЙГ УДИРДДАГ БАЙДАЛ

Энэхүү стандарт нь байгаль орчны гадаад эрсдэлийн удирдлагыг авч үздэг. Уг стандартын дагуу бичил санхүүгийн байгууллагууд санхүүжүүлэх үйл ажиллагаа, төслийг байгаль орчны эрсдэлийн түвшингээр үнэлэх тухай юм. Тус байгаль орчны эрсдэлийн түвшин нь зээл олгох үйл ажиллагааны нэг шалгуур болох эсвэл байгаль орчинтой холбоотой асуудлыг бууруулах талаар харилцагчийн мэдлэгийг нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтад нь нөлөөлж болно.


Хүснэгт 10 Байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг байдал

Стандарт 3.	Байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг эсэх	Дундаж хувь
<b>Үндсэн практик</b>	<b>Тухайн байгууллага нь харилцагчийн байгаль орчны эрсдэлийг үнэлдэг эсэх</b>	<b>11.8%</b>
Үзүүлэлт	Тухайн байгууллага харилцагчийн үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчны эрсдэлийг үнэлэх тусгай арга хэрэгсэл ашигладаг эсэх	8.9%
Үзүүлэлт	Тухайн байгууллага харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны эрсдэлийг хэрхэн үнэлэх талаар зээлийн ажилтнаа сургадаг эсэх	14.6%
<b>Үндсэн практик</b>	<b>Тухайн байгууллага харилцагчийн байгаль орчны эрсдэлийн түвшинг үнэлэх хүчин зүйлийг зээлийн бодлого, журамдаа оруулсан эсэх</b>	<b>10.8%</b>
Үзүүлэлт	Тухайн байгууллага зээлийн өргөдлийг байгаль орчны эрсдэлийн түвшингээр ангилж, эрсдэлийн ангилал тус бүрийн дагуу тусгай процедур хэрэгжүүлдэг эсэх	10.8%
<b>Үндсэн практик</b>	<b>Тухайн байгууллага байгаль орчны эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг дэмждэг эсэх</b>	<b>8.7%</b>
Үзүүлэлт	Тухайн байгууллага харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны эрсдэл болон түүнийг бууруулах стратегийн талаар таниулах үйл ажиллагаа зохион байгуулдаг эсэх	8.7%
	<b>Нийт дундаж үнэлгээ</b>	<b>10.8%</b>

Дээрх хүснэгтээс харахад байгаль орчны гадаад эрсдэлийн удирдлага 10.8 хувь буюу хангалтгүй үнэлгээтэй байна. Энэ нь судалгаанд хамрагдсан байгууллагуудын хувьд байгаль орчны гадаад эрсдэлийг үнэлэх аргачлал дутмаг, зээлийн бодлого журмаараа дамжуулан зээлдэгчийн байгаль орчны эрсдэлийг үнэлж, ангилах улмаар

харилцагчийн байгаль орчны эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэн, дэмжих байдал хангалтгүй байгааг илтгэж байна. Энэхүү стандартын үзүүлэлт тус бүрийн үнэлгээг графикаар харуулбал дараах байдалтай байна.


График 16 Стандарт 3-ын гүйцэтгэлийн үзүүлэлт тус бүрийн дундаж үнэлгээ



Дээрх графикаас харахад стандарт 3-ын хувьд харилцагчийн байгаль орчны гадаад эрсдэлийг бууруулах, түүнийг таниулах ажиллагаа 8.7 хувь, мөн зээлдэгчийн байгаль орчны эрсдэлийг үнэлэхдээ тусгай арга хэрэгсэл ашигладаг байдал 8.9 хувь буюу хангалтгүй, харин байгаль орчны эрсдэлийг хэрхэн үнэлэх талаар зээлийн ажилтнаа сургаж хөгжүүлдэг байдал нь бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад өндөр буюу 14.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Байгаль орчны гүйцэтгэлийн ногоон индексийн стандарт 3-ийг хэрэгжүүлдэг эсэхийг судалгаанд хамрагдсан 263 ББСБ-уудын хувьд үзүүлэлт тус бүрээр нэгтгэн доорх графикаар харууллаа.

График 17 Судалгаанд оролцогчдын байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг байдал



Дээрх графикаас харахад судалгаанд оролцогчдын 14 хувь нь харилцагчийн байгаль орчны эрсдэлийг үнэлэх тусгай арга хэрэгсэлтэй, үлдсэн 86 хувь нь харилцагчийн байгаль орчны эрсдэлийг үнэлэх тусгай арга хэрэгсэлгүй байна. Мөн судалгаанд хамрагсдын 22 хувь нь харилцагчийн байгаль орчны эрсдэлийг хэрхэн үнэлэх, харилцагчийн үйл ажиллагааны аюулыг хэрхэн шалгах талаар зээлийн ажилтнуудаа сургаж хөгжүүлдэг гэсэн бол 77 хувь нь энэ талаар зээлийн ажилтнууддаа сургалт явуулдаггүй гэж хариулсан байна.

Нийт 263 байгууллагын 18 хувь нь зээлийн өргөдлийг харилцагчийн байгаль орчны эрсдэлийн түвшингээр ангилдаг бол 82 хувь нь тус эрсдэлийн түвшингээр зээлийн өргөдлийг ангилдаггүй, 14 хувь нь зээлдэгчийн байгаль орчны эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа хэрэгжүүлдэг бол 86 хувь нь байгаль орчны эрсдэлийг бууруулах талаар ямар нэгэн ажил хийдэггүй гэж хариулсан байна.

Дээрх судалгааны үр дүнгээс байгаль орчны эрсдэлийг үнэлэх хүн хүчний нөөц дутмаг, мэдлэг туршлага хангалтгүй, мөн хариуцсан зээлийн ажилтнуудаа байгаль орчны эрсдэлийг хэрхэн үнэлэх талаар сургаж хөгжүүлэх байдал дутмаг байна гэж ажиглагдлаа.

### 8.2.5. НОГООН ИНДЕКС 2.0 – СТАНДАРТ 4 НОГООН БОЛОМЖИЙГ ДЭМЖИЖ, УРАМШУУЛДАГ БАЙДАЛ

Энэхүү стандарт нь бичил санхүүгийн байгууллагууд нь сэргээгдэх эрчим хүч, тогтвортой хөдөө аж ахуй эсвэл байгаль орчинд ээлтэй бизнес, үйл ажиллагааг дэмжих тусгай санхүүгийн болон санхүүгийн бус

үйлчилгээнүүдийг санал болгох замаар хэрхэн ногоон боломжуудыг дэмжиж, урамшуулах. Цаашлаад байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлтөд чиглэсэн харилцагчийн үйл ажиллагааны уян хатан байдлыг нэмэгдүүлэхэд чиглэдэг.

Хүснэгт 11 Ногоон боломжийг дэмжиж, урамшуулдаг байдал

Стандарт 4.	Ногоон боломжийг дэмжиж, урамшуулдаг эсэх	Дундаж хувь
<b>Үндсэн практик</b>	<b>Тухайн байгууллага байгаль орчинд ээлтэй цэвэр эрчим хүчинд (clean energy) зориулсан тусгай санхүүгийн бүтээгдэхүүн санал болгодог эсэх</b>	<b>14.3%</b>
Үзүүлэлт	Тухайн байгууллага сэргээгдэх эрчим хүч эсвэл эрчим хүчний хэмнэлтэд зориулсан тусгай зээлийн бүтээгдэхүүнийг санал болгодог эсэх	14.3%
<b>Үндсэн практик</b>	<b>Тухайн байгууллага тогтвортой эсвэл байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуйд зориулсан тусгай санхүүгийн бүтээгдэхүүн санал болгодог эсэх</b>	<b>14.1%</b>
Үзүүлэлт	Тухайн байгууллага тогтвортой эсвэл байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуйг (Climate-smart agriculture) дэмжих тусгай зээлийн эсвэл бусад санхүүгийн үйлчилгээ санал болгодог эсэх	14.1%
<b>Үндсэн практик</b>	<b>Тухайн байгууллага бусад ногоон санхүүгийн эсвэл санхүүгийн бус бүтээгдэхүүн санал болгодог эсэх</b>	<b>11.6%</b>
Үзүүлэлт	Тухайн байгууллага байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжихэд (сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, дахин боловсруулалт, хог хаягдлын менежмент, цэвэр ус гэх мэт) зориулсан зээлийн бүтээгдэхүүн санал болгодог эсэх	17.7%
Үзүүлэлт	Тухайн байгууллага харилцагчдадаа байгаль орчны эрсдэлээс хамгаалах зорилго бүхий бичил даатгалын бүтээгдэхүүнийг шууд эсвэл гуравдагч талтай хамтран санал болгодог эсэх	10.8%
Үзүүлэлт	Тухайн байгууллага харилцагчиддаа өөрөө шууд эсвэл байгаль орчны байгууллагатай хамтрах замаар хэрхэн байгаль орчинд ээлтэй бизнес эрхлэх чиглэлээр сургалт явуулдаг эсэх	6.3%
	<b>Нийт дундаж үнэлгээ</b>	<b>12.6%</b>

Стандарт 4-ийн үр дүнд судалгаанд хамрагдсан байгууллагуудын ногоон боломжийг дэмжиж урамшуулдаг байдал 12.6 хувь буюу хангалтгүй үнэлгээтэй байна.

Энэхүү стандартын үзүүлэлт тус бүрийг үнэлгээг графикаар харуулбал дараах байдалтай байна.



График 18 Стандарт 4-ын гүйцэтгэлийн үзүүлэлт тус бүрийн дундаж үнэлгээ



Дээрх графикаас үзвэл стандартын 4-ийн хувьд тухайн байгууллага байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжихэд (сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, дахин боловсруулалт, хог хаягдлын менежмент, цэвэр ус гэх мэт) зориулсан зээлийн бүтээгдэхүүн санал болгодог эсэх нь бусад үзүүлэлтүүдээс харьцангуй өндөр буюу 17.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа.

Харин тухайн байгууллага харилцагчиддаа шууд эсвэл байгаль орчны байгууллагатай хамтран “хэрхэн байгаль орчинд ээлтэй бизнес эрхлэх” чиглэлээр сургалт явуулдаг байдал хамгийн бага буюу 6.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Байгаль орчны гүйцэтгэлийн ногоон индексийн стандарт 4-ийг хэрэгжүүлдэг эсэхийг судалгаанд хамрагдсан 263 ББСБ-уудын хувьд үзүүлэлт тус бүрээр нэгтгэн дүгнэж доорх графикаар илэрхийллээ.

График 19 Судалгаанд оролцогчдын ногоон боломжийг дэмжиж урамшуулдаг байдал




График 19-с харахад судалгаанд оролцогчдын 20 гаруй хувь нь тодорхой хэмжээнд байгаль орчинд ээлтэй сэргээгдэх эрчим хүч, эрчим хүч хэмнэх, болон хөдөө аж ахуйд зориулсан зээлийн бүтээгдэхүүнийг харилцагч нартаа санал болгодог бол 80 орчим хувь огт энэ төрлийн зээлийн бүтээгдэхүүн санал болгодоггүй гэж хариулсан байна.

Мөн судалгаанд оролцогчдын 15 хувь нь харилцагч байгууллага болон иргэдэд байгаль орчны эрсдэлээс хамгаалахад чиглэгдсэн бичил даатгалын бүтээгдэхүүнийг санал болгодог бол 85 хувь нь бичил даатгалын үйлчилгээг огт санал болгодоггүй гэж хариулсан байна.

Судалгаанд оролцогчдын 9 хувь нь байгаль орчинд ээлтэй бизнес хэрхэн эрхлэх талаар харилцагч нартаа сургалт, мэдээлэл өгөх, таниулах үйл ажиллагаа явуулдаг бол 90 хувь нь энэ төрлийн үйл ажиллагаа огт явуулдаггүй гэж хариулсан байна.

Эндээс ББСБ-уудын хувьд байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг дэмжихэд чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээ хангалтгүй байгаагаас гадна харилцагч, зээлдэгч нарт энэ чиглэлийн мэдээлэл, таниулах үйл ажиллагааг хангалттай хийхгүй байна. Энэ нь ББСБ-уудын хувьд байгаль орчны эрсдэл, ногоон зээлтэй холбоотой албан ёсны бодлого байхгүй; нөгөөтэйгүүр зээлийн ажилтнуудын мэдлэг сул байгаа нь ногоон бичил санхүүгийн бүтээгдэхүүнтэй холбоотой стандартын гүйцэтгэл доогуур гарахад томоохон нөлөө үзүүлсэн байна.

### 8.3. “НОГООН ИНДЕКС 2.0” ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

“Ногоон индекс 2.0” аргачлалын чанарын үзүүлэлт нь байгаль орчны гүйцэтгэлийг 4 стандартын хүрээнд хэмжиж үнэлдэг. Харин тоон үзүүлэлт нь зарим чанарын үзүүлэлтүүдийг нарийвчлан судалж дүгнэх боломж олгодог.


#### 8.3.1. Цахилгаан, ус, цаас, шатахууны хэрэглээний өөрчлөлт

Танай байгууллага өөрийн төв болон салбар нэгжүүдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ, ус, цаас болон шатахууны хэрэглээний бууралтыг жил бүр хэмжиж хяналт тавьж, тайлагнадаг уу?
Хэрвээ танай байгууллага дотоод экологийн ул мөр (цахилгаан эрчим хүч, ус, цаас, шатахууны хэрэглээний бууралт)-ийг хянаж, удирддаг бол дараах хүснэгтийг бөглөнө үү.
Цахилгаан эрчим хүчний хэрэглээний бууралтыг хянахад хялбар байх эсвэл цаашид хэмнэх эсэх шийдвэр гаргахад дээрх мэдээ хэрэгтэй гэж бодож байна уу?

График 20 Экологийн дотоод ул мөрийг хянахад хялбар болон ШГ-д хэрэгтэй эсэх



График 21 Цахилгаан, ус, цаас, шатахууны хэрэглээний өөрчлөлтийг хянадаг эсэх.



Хүснэгт 12 Экологийн дотоод ул мөрийн өөрчлөлт.

Үзүүлэлт (B2.1)	Дундаж өөрчлөлт	Өсөлт /бууралт/	Ажиглалтын тоо
Төв болон салбар нэгжүүдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ (квт, мөнгөн дүнгээр)	14%	Өсөлт	60
Төв болон салбар нэгжүүдийн усны хэрэглээ (м3, мөнгөн дүнгээр)	7%	Өсөлт	47
Төв болон салбар нэгжүүдийн цаасны хэрэглээ (кг эсвэл боодол, мөнгөн дүнгээр)	23%	Өсөлт	90
Төв болон салбар нэгжүүдийн шатахууны хэрэглээ (литр, мөнгөн дүнгээр)	40%	Бууралт	80

Судалгааны үр дүнгээс нийт судалгаанд хамрагдсан байгууллагуудын 18-34 хувь орчим нь өөрсдийн төв болон салбар нэгжүүдийн цахилгаан, ус, цаас болон шатахууны хэрэглээгээ хянадаг хэмээн тодорхойлж харгалзах тоон үзүүлэлтээ ирүүлсэн байна. Дээрх хүснэгтэд үзүүлсэнчлэн цахилгаан эрчим хүч, ус болон цаасны хэрэглээ нь 2019 онд 2018 оноос тус тус харгалзан 14 хувь, 7 хувь, болон 23 хувиар өссөн үзүүлэлттэй байсан бол шатахууны хэрэглээний хувьд 40 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Дээрх үзүүлэлтүүдийг хянадаг гэж хариулсан байгууллагуудын хувьд 61 хувь нь тус үзүүлэлтүүдийг хянахад хялбар гэж үзсэн ба үүнээс 39 хувь нь тус үзүүлэлтүүдийг

хянаснаар шийдвэр гаргахад хэрэгтэй гэж үзсэн байна.

Үзүүлэлтийн тайлбар ба санал болгох өөрчлөлтүүд: Цахилгаан эрчим хүч, ус, цаасны хэрэглээ өссөнөөс үзвэл жил ирэх тусам ББСБ-уудын үйл ажиллагаа нь өргөжин тэлж ашиглах нөөцүүд ч мөн нэмэгдсэн хэмээн таамаглаж байна. Харин, сүүлийн үед дэлхий нийтээрээ байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах, үүний тулд тог цахилгаан, ус, цаас зэрэг нөөцүүдийг хэмнэлттэй ашиглах олон кампанит ажил болон уриалгууд эрчимжээд байгаа билээ. Гэтэл эдгээр нөөцийн хэрэглээ өссөн байгаа нь тэр дундаа 90 байгууллагын дундаж үзүүлэлтээр цаасны хэрэглээ 20 хувиар өссөн байгаа нь анхаарал татахуйц үзүүлэлт байна. Харин шатахууны хэрэглээ их хэмжээгээр буюу 40 хувиар буурсан байгаа нь мөн нэмэлт тайлбар, үндэслэл хэрэгтэй. Үүнээс үзвэл судалгаанд хамрагдсан байгууллагуудад цахилгаан эрчим хүчний нөөцийг хэмнэлттэй зарцуулах тодорхой бодлого, зохицуулалт байхгүй байна гэж үзэж байна.

Стандарт 2: Байгаль орчны дотоод эрсдлийн удирдлагын дундаж үнэлгээ бусад 3 стандартаас өндөр үзүүлэлттэй байсан нь энэ үзүүлэлтийн хувьд ажиглалтын тоо өндөр байх гол шалтгаан ба тоон үзүүлэлтүүдээ илгээсэн байгууллагуудын хэмжээ нь Ногоон индекс 2.0-н чанарын үзүүлэлтийг бататгаж байна.


### 8.3.2. Харилцагчид болон олон нийтэд зориулсан мэдээлэл өгөх, сургалтын үйл ажиллагаа

Танай байгууллага харилцагчид болон олон нийтэд зориулж ногоон бизнес/боломж/технологи болон байгаль орчны эрсдэлийн талаар явуулдаг мэдлэг мэдээлэл олгох болон сургалтын үйл ажиллагааныхаа тоог хянадаг уу?
Хэрвээ танай байгууллага харилцагчид болон олон нийтэд зориулсан байгаль орчны эрсдэлийн талаар явуулдаг мэдлэгийг тэлэх болон сургалтын үйл ажиллагааны талаарх тоог хянадаг бол дараах хүснэгтийг бөглөнө үү
Харилцагчид болон олон нийтэд зориулсан сургалтын тоог хянахад хялбар болон цаашид шийдвэр гаргахад хэрэгтэй гэж бодож байна уу?

График 22 Сургалтын үйл ажиллагааг хянахад хялбар болон ШГ-д хэрэгтэй эсэх



График 23 ОН-д чиглэсэн сургалтын үйл ажиллагаа явуулж, хянадаг эсэх



Хүснэгт 13 ОН-д чиглэсэн сургалтын үйл ажиллагаа явуулсан тоо, өсөлтийн хэмжээ

Үзүүлэлт	2019 оны байдлаар	Өсөлт /бууралт/	Ажиглалтын тоо
Ногоон бизнес/боломж/ болон технологийн талаарх мэдлэг тэлэх үйл ажиллагаа болон сургалтын үйл ажиллагааны тоо	10	43% Өсөлт	10
Байгаль орчны эрсдэлийн талаар мэдлэг тэлэх үйл ажиллагаа болон сургалтын үйл ажиллагааны тоо	8	60% Өсөлт	10

Судалгааны үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан байгууллагуудын 14 хувь нь ногоон бизнес, байгаль орчны эрсдэлийн талаар мэдлэг тэлэх, сургалтын үйл ажиллагаа тодорхой хэмжээнд явуулдаг хэмээн хариулсан боловч ердөө 3.8 хувь буюу 10 байгууллага ногоон энэ төрлийн үйл ажиллагаа явуулсан тоогоо ирүүлсэн байна. 2019 оны байдлаар нийтдээ 10 ногоон боломжийн болон технологийн талаарх мэдлэг тэлэх үйл ажиллагаа явуулсан гэх ба энэ нь өмнөх онтой харьцуулахад 43 хувиар өссөн дүн юм. Харин байгаль орчны эрсдэлийн талаар мэдлэг тэлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллагын тоо мөн адил 10 байсан ба 2019 онд ердөө 8 ийм төрлийн сургалтын үйл ажиллагаа явуулсан гэж хариулсан байна. Нийт энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг ба үүнийгээ хянадаг байгууллагуудын 39 хувь нь хянахад хялбар, үүнээс 29 хувь нь шийдвэр гаргалтад хэрэгтэй гэж үзсэн байна.

Үзүүлэлтийн тайлбар ба санал болгох өөрчлөлтүүд: Харилцагчиддаа хандсан ногоон бизнес, байгаль орчны эрсдэлийн талаарх таниулах сургалтын үйл ажиллагаа явуулж буй байгууллагын тоо болон зохион байгуулсан сургалтын тоо Олон улсын жишигтэй харьцуулахад маш бага байгаа нь манай улсын ББСБ-уудын өөрсдийн ногоон боломж, технологи, байгаль орчны эрсдэлийн талаарх мэдлэг мэдээлэл муу, эсвэл ийм төрлийн үйл ажиллагаа явуулах нөөц, боломж хангалтгүй байгааг илтгэж байна. Европын 87 БСБ-аас авсан судалгааны үр дүнд 2014 оны жилийн эцсийн байдлаар ногоон боломж болон байгаль орчны эрсдэлийн талаар явуулсан сургалтын үйл ажиллагаа нь тус тус 1,539 ба 4,919 байсан нь манайд энэ төрлийн үйл ажиллагаа маш хангалтгүй байгааг илтгэж байна.


### 8.3.3. Зээлийн өргөдөл хүлээн авах үеийн байгаль орчны эрсдэлийн үнэлгээ

Танай байгууллага байгаль орчин, нийгмийн өндөр эрсдэлтэй учраас татгалзсан зээлийн нийт өргөдлийн тоог хянадаг уу?
Хэрвээ танай байгууллага зээлийн өргөдлийг үнэлж, хянадаг бол гэж хариулсан бол дараах хүснэгтийг бөглөнө үү.
Байгаль орчны шалгуураар татгалзсан зээлийн өргөдлийн тоог хянахад хялбар эсвэл цаашдын зээлийн шийдвэр гаргалтад хэрэгтэй гэж та бодож байна уу?

График 24 Зээлийн өргөдлийг үнэлж хянахад хялбар, ШГ-д хэрэгтэй эсэх



График 25 Зээлийн өргөдлийг үнэлж, хянадаг эсэх



## Хүснэгт 14 Зээлийн өргөдлийн тооны өөрчлөлт

Үзүүлэлт	Дундаж өөрчлөлт	Өсөлт /бууралт/	Ажиглалтын тоо
Тайлант жилд хүлээн авсан зээлийн өргөдлийн тоо	16%	Өсөлт	24
Тайлант жилд байгаль орчин, нийгмийн өндөр эрсдэлтэй тул татгалзсан зээлийн өргөдлийн тоо	102%	Өсөлт	24

Судалгааны үр дүнгээс харахад тайлант жилд байгаль орчин, нийгмийн өндөр эрсдэлтэй тул татгалзсан зээлийн өргөдлийн тоо нь тооцож гаргахад хэцүү үзүүлэлтийн нэг юм. Тиймээс ч судалгаанд хамрагдсан нийт ББСБ-уудын 49 хувь нь тодорхой хэмжээнд зээлийн өргөдлийг үнэлдэг боловч тэдгээрээс 10 хувь буюу 24 байгууллага уг тоог ирүүлсэн байна. Өмнөх онтой харьцуулахад 2019 онд хүлээж авсан нийт зээлийн өргөдлийн тоо болон байгаль орчны эрсдэл өндөр учраас татгалзсан зээлийн тоо өсөлттэй байсан ба дундаж өөрчлөлт нь харгалзан 16 хувь болон 102 хувь байсан.

Үзүүлэлтийн тайлбар ба санал болгох өөрчлөлтүүд: Байгууллага тус бүрийн байгаль орчны эрсдэлийг хэрхэн үнэлж байгаа, үүнтэй холбоотой бодлого, дүрэм журмын ялгаатай байдлаас үүдэн энэхүү үзүүлэлтэд тайлбар өгөх нь амаргүй байдаг. Гэвч эрсдэл өндөртэй хэмээн татгалзсан зээлийн өргөдлийн тоо 102% буюу 2 дахин өссөн үзүүлэлтийг нягтлан шалгаж, учир шалтгааныг тодруулах шаардлагатай.


#### 8.3.4. Зээлийн үлдэгдлийн байгаль орчны эрсдэлийн үнэлгээ

Танай байгууллага байгаль орчны эрсдэлтэй гэж үнэлэгдсэн зээлийн үлдэгдлийг хянадаг уу?
Хэрвээ танай байгууллага байгаль орчны эрсдэлтэй гэж үнэлсэн зээлийн үлдэгдлийг хянадаг бол дараах хүснэгтийг бөглөнө үү.
Байгаль орчны эрсдэлтэй гэж үзсэн зээлийн үлдэгдлийн талаарх энэхүү мэдээллийг хянахад хялбар, эсвэл цаашдын шийдвэр гаргалтад хэрэгтэй гэж бодож байна уу?

График 26 БОЭ-г үнэлж, хянахад хялбар, шийдвэр гаргахад хэрэгтэй эсэх



График 27 БОЭ-г үнэлж, хянадаг эсэх



## Хүснэгт 15 БОЭ-тэй зээлийн үлдэгдлийн өөрчлөлт

Үзүүлэлт	Дундаж өөрчлөлт	Өсөлт /бууралт/	Ажиглалтын тоо
Байгаль орчны эрсдэлтэй гэж үнэлэгдсэн зээлийн үлдэгдлийн тоо	35%	Өсөлт	30
Нийт зээлийн үлдэгдлийн хэмжээ	47%	Өсөлт	30

Судалгааны үр дүнгээс харахад энэхүү үзүүлэлтийн хувьд байгаль орчны эрсдэлтэй гэж үнэлэгдсэн зээлийн үлдэгдлийн тоо болон хэмжээний өөрчлөлтийг харуулсан. Нийт судалгаанд хамрагдагсдын 17 хувь нь байгаль орчны эрсдэлийг үнэлдэг ба хянадаг хэмээн мэдэгдсэн ба тэдгээрээс 30 байгууллага эрсдэлтэй зээлийн үлдэгдлийн тоо ба хэмжээг ирүүлсэн байна. Тус үзүүлэлт нь өмнөх онтой харьцуулахад 35 болон 47 хувийн өсөлттэй байна. Эрсдэлтэй зээлийн үлдэгдлийг хянахад хялбар бөгөөд шийдвэр гаргалтад хэрэгтэй хэмээн байгууллагуудын 22 хувь нь үзсэн бол 41 хувь нь хянахад хэцүү хэмээн үзсэн байна.

Үзүүлэлтийн тайлбар ба санал болгох өөрчлөлтүүд: Дээрх үзүүлэлт нь 2018 оноос тоо болон хэмжээний хувьд багагүй хэмжээгээр өссөн байгаа нь манай ББСБ-ууд байгаль орчны эрсдэлийг үнэлэх өөрсдийн арга хэрэгсэл, дүрэм журмыг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой байж магадгүй. Тиймээс ч байгууллага бүрийн ашиглаж буй арга хэрэгсэл, дүрэм журмын ялгаатай байдлаас үүдэн дээрх үзүүлэлтэд шууд дүгнэлт хийх нь өрөөсгөл юм. Тус эрсдэлийг үнэлдэг 30 байгууллагуудаас ихэнх нь 2019 оноос эхлэн шинэ дүрэм, журам гаргасан эсвэл журмаа шинэчилсэн байх магадлалтай тул энэхүү үзүүлэлттэй холбоотойгоор 2017 он болон 2020 оны дүнг авч харьцуулах, ийм хэмжээгээр өсөх болсон учир шалтгааныг тодруулах шаардлагатай.

## 8.3.5. Ногоон зээл

Танай байгууллага нийт олгосон ногоон зээлийн тоог хэмжиж, тайлагнадаг уу? (Тайлбар: “Ногоон зээл” гэдэг нь байгаль орчинд эерэг үр дагавар үзүүлэх зорилго бүхий байгаль орчинд ээлтэй санхүүгийн бүтээгдэхүүнийг хэлнэ. Жишээлбэл: сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт, органик ферм, хог хаягдлын менежмент, цэвэр ус зэргийг дэмжсэн гэх мэт)

Хэрвээ танай байгууллага олгосон ногоон зээлийн хэмжээг хянадаг бол дараах хүснэгтийг бөглөнө үү.

Дээрх мэдээлэл нь ногоон зээлийн тоог хянахад хялбар болон цаашид ногоон зээлийг хөгжүүлэх тухай шийдвэр гаргахад хэрэгтэй мэдээлэл гэж та бодож байна уу?

График 28 Ногоон зээлийн үлдэгдлийг хянахад хялбар, ШГ-д хэрэгтэй эсэх



График 29 Ногоон зээл олгож, хянадаг эсэх



## Хүснэгт 16 Олгосон ногоон зээлийн хэмжээ, салбараар

Үзүүлэлт	2018 он			2019 он			Өөрчлөлтийн хувь
	Ажиг. тоо	Нэгж	Мян.төг	Ажиг. тоо	Нэгж	Мян.төг	
Тайлант жилд нийт олгосон зээлийн хэмжээ	6.00	697.90	5,326,766.02	21.00	1,012.19	7,633,425.48	45%
Тайлант жилд олгосон нийт ногоон зээлийн хэмжээ	6.00	234.70	3,216,019.48	7.00	350.14	1,700,640.62	49%
<b>Үүнээс:</b>							
Сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй төсөл, бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүжүүлэхэд зориулж олгосон зээлийн хэмжээ	3.00	279.00	2,525,045.30	4.00	375.67	1,204,116.54	35%
Тогтвортой, цаг уурын ухаалаг шийдэл бүхий хөдөө аж ахуй (climate-smart agriculture)-н зориулалттайгаар олгосон зээлийн хэмжээ	1.00	2.00	350,000.00	2.00	1,501.50	1,025,000.00	74975%
Тайлангийн жилд олгосон бусад ногоон зээлийн бүтээгдэхүүний хэмжээ	2.00	424.00	2,875,193.37	4.00	1,105.75	3,506,180.25	161%
Хөдөө аж ахуйн болон цаг уурын бичил даатгалын гэрээтэй зээлдэгчийн тоо							

Нийт судалгаанд хамрагдсан байгууллагуудын 16 хувь нь ногоон зээл олгодог гэсэн бол зөвхөн 3 хувь нь ногоон зээлээ хянадаг бөгөөд тайлагнадаг байв. Эдгээр 6 байгууллагуудаас олгосон зээлийн тоо болон хэмжээг дээрх хүснэгтэд үзүүлэв. Тус 6 байгууллагын 50 хувь нь ногоон зээлээ сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй төсөл, бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүжүүлэхэд зориулж олгосон байв.

Үзүүлэлтийн тайлбар ба санал болгох өөрчлөлтүүд: Судалгааны

үр дүнд хэдийгээр цөөхөн байгууллага ногоон зээл олгож байгаа ч олгосон зээлийн хэмжээ нь харьцангуй өндөр байгаа нь харагдаж байна. Тогтвортой, цаг уурын ухаалаг шийдэл бүхий хөдөө аж ахуйн зориулалттай зээлийн өөрчлөлтийн хэмжээ даруй 749 дахин өссөн байгаа үзүүлэлтийг цаашид нэмж судлах шаардлагатай хэмээн үзэж байна. Энэ өсөлтийн хэмжээ нь бодит бус мөн итгэл төрүүлэхүйц бус байгаа тул нэмэлт дүгнэлт өгөх боломжгүй хэмээн үзэж байна. Үүнд ББСБ-уудын цаг уурын ухаалаг шийдэл бүхий хөдөө аж ахуй хэмээх ойлголтын тодорхойлолт, шалгуур үзүүлэлтүүдийг нарийвчлан шинжлэх хэрэгтэй. Ингэснээр дээрх их хэмжээний өсөлттэй тоон үзүүлэлтийн үнэн зөв байдлыг тодорхойлох боломжтой болох юм.

### 8.3.6. Байгаль орчны гамшигт тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд идэвхтэй бичил даатгал

Танай байгууллага байгаль орчны гамшигт (жишээ нь: цаг агаарын цочрол, цаг уурын өөрчлөлт гэх мэт) тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд бичил даатгалд хамрагдсан зээлдэгчдийн тоог хянадаг уу?
Хэрвээ танай байгууллага бичил даатгалд хамрагдсан зээлдэгчийн тоог хянадаг бол дараах хүснэгтийг бөглөнө үү.
Энэхүү бичил даатгалд хамрагдсан зээлдэгчийн тооны талаарх мэдээллийг хянахад хялбар, эсвэл цаашдын шийдвэр гаргалтад хэрэгтэй гэж та бодож байна уу?

График 30 БД-н бүтээгдэхүүн санал болгож, хянадаг эсэх





График 31 БД-н бүтээгдэхүүнээ хянахад хялбар, ШГ-д хэрэгтэй эсэх



Хүснэгт 17 БД-ын гэрээтэй зээлдэгчийн тоо, өөрчлөлт

Үзүүлэлт	2019 оны байдлаар	Дундаж өөрчлөлт	Өсөлт / бууралт/	Ажиглалтын тоо
Байгаль орчны гамшигт тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд идэвхтэй бичил даатгалын гэрээтэй зээлдэгчийн тоо	749	68%	Өсөлт	16
Нийт зээлдэгчийн тоо	949	50%	Өсөлт	16

Судалгааны үр дүнгээс харахад судалгаанд хамрагдсан ББСБ-уудын зөвхөн 12 хувь нь байгаль орчны гамшигийн эрсдэлийг бууруулах бичил даатгалын үйлчилгээ санал болгодог хэмээн мэдэгдсэн байна. Тэдгээрээс 16 байгууллага зээлдэгчийн тоон мэдээллийг ирүүлсэн. 2019 оны байдлаар нийт 749 ийм төрлийн даатгалын гэрээтэй харилцагчид байгаа, энэ нь өнгөрсөн оноосоо 68 хувиар өссөн үзүүлэлт юм.

Үзүүлэлтийн тайлбар ба санал болгох өөрчлөлтүүд: Дээрх үр дүнгээс харахад 1 жилийн дотор бичил даатгалын үйлчилгээнд хамрагдсан зээлдэгчийн тооны өсөлт нь мөн хугацаанд нэмэгдсэн шинэ ногоон зээлдэгчийн тооны өсөлт болох 49 хувийн үзүүлэлтээс 20 орчим

хувиар илүү байгаа нь ББСБ-ууд шинэ зээлдэгч бүрээ бичил даатгалд хамруулахаас гадна хуучин зээлдэгчдээ ч мөн даатгуулсан байгааг харуулж байна. Харин эдгээр даатгалд хамрагдсан зээлдэгчдийн даатгалын гэрээнд байгаль орчны гамшгийн эрсдэлээс хамгаалах заалт байгаа эсэхийг дахин шалгаж тодруулах шаардлагатай. Бичил даатгал нь бага орлоготой бичил бизнес эрхлэгчдэд зориулсан, хөнгөлөлттэй нөхцөлтэй даатгалын бүтээгдэхүүн гэдгээрээ уламжлалт даатгалын гэрээнээс ялгардаг (Ahmed, 2016). Тиймээс судалгаанд хамрагдсан байгууллагуудын зээлдэгчдийн даатгалын гэрээний нөхцөлийг тодруулж үзэх нь зүйтэй.

### 8.3.7. Байгаль орчны гүйцэтгэлийн тоон үзүүлэлтийн дүгнэлт

Хүснэгт 18 БОГ-ийн тоон үзүүлэлтийн дүгнэлт

Үзүүлэлт	Хийдэг	Хянахад хялбар	Шийдвэр гаргахад хэрэгтэй
Ногоон зээл санал болгодог.	13%	33%	45%
Цахилгаан эрчим хүчний хэрэглээ, ус, цаас болон шатахууны хэрэглээний бууралтыг жил бүр хэмжиж хянадаг	49%	51%	63%
Харилцагчид болон олон нийтэд зориулж ногоон бизнес/боломж/ технологи болон байгаль орчны эрсдэлийн талаар мэдлэг мэдээлэл олгох болон сургалтын үйл ажиллагаа явуулдаг.	14%	39%	46%
Байгаль орчны гамшигт тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх бичил даатгалд хамрагдсан зээлдэгчдийн тоог хянадаг.	6%	21%	37%
Байгаль орчин, нийгмийн өндөр эрсдэлтэй учраас татгалзсан зээлийн нийт өргөдлийн тоог хянадаг.	16%	38%	46%
Байгаль орчны эрсдэлтэй гэж үнэлэгдсэн зээлийн үлдэгдлийг хянадаг.	17%	30%	46%

Судалгааны тоон үзүүлэлтийн үр дүн манай улсын нийт ББСБ-уудын төлөөлөл ногоон зээлийн үйлчилгээ, үүнтэй холбоотой бусад байгаль орчныг хамгаалах, үүний тухай мэдлэг мэдээлэл өгөх зэрэг гадаад үйл ажиллагааг ердөө 6-аас 17 хувь орчим байгууллага санал болгодог байна. Харин, манай байгууллагуудын 49 хувь нь дотоод экологийн ул мөрийг багасгах ажлын эхний алхам болох өөрсдийн цахилгаан эрчим хүч, ус, цаас болон шатахууны хэрэглээний бууралтыг жил бүр хэмжиж хянадаг нь сайшаалтай.

Нөгөөтээгүүр дотоод ул мөрийн үзүүлэлтүүд нь санхүүгийн тайланд зардлаар бүртгэгдэж байгаа учраас хянахад хялбар хэмээн нийт байгууллагуудын 51 хувь нь үзсэн бол 63 хувь нь шийдвэр гаргахад хэрэгтэй хэмээн үзсэн байна. Энэ нь бусад тоон үзүүлэлтүүдээс хамгийн өндөр үзүүлэлт байна. Харин бичил даатгалд хамрагдсан харилцагчдийн тоог хянах нь хамгийн хэцүү бөгөөд энэ нь шийдвэр гаргахад хамгийн хэрэггүй хэмээн дийлэнх байгууллагууд үзсэн байна.


Судалгааны асуулгыг бөглөж илгээсэн ажилтан нь дээрх үзүүлэлтүүдийг хэмжиж, хянадаг ажилтан биш байх магадлалтай учраас зарим байгууллагууд тоон үзүүлэлтээ илгээгээгүй эсвэл дутуу илгээсэн байж болзошгүй. Мөн дээрх үр дүнгээс харвал тоон үзүүлэлтээ хэмжих хангалттай хөшүүрэг байхгүй хэмээн үзэж байна.

Эцэст нь статистикийн шинжилгээгээр нийт судалгаанд оролцогчдын байгаль орчны гүйцэтгэлийн тоон үзүүлэлтээ хэмжиж тайлагнаж байгаа хэсэг нь маш бага ба цаашид ББСБ-уудын тоон үзүүлэлтээ хэмжиж тайлагнах, өөрсдийн шийдвэр гаргалтдаа ашиглахыг идэвхжүүлэх ажлууд хийх, улмаар байгууллага бүр хөгжлийн зорилгодоо байгаль орчны стратегиа нэгтгэх ажилд нь зохицуулах байгууллагын оролцоо, дэмжлэг чухал гэж үзэж байна.

## 8.4. НОГООН БИЧИЛ САНХҮҮЖИЛТИЙН БОЛОМЖ, СОРИЛТ

Судалгаанд хамрагдсан 263 ББСБ-ийн 23 хувь нь ирэх жилээс аливаа нэг төрлийн ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчиддаа санал болгох төлөвлөгөө байгаа гэж хариулсан бол 30 хувь нь ногоон бүтээгдэхүүн гаргах төлөвлөгөө байхгүй, 47 хувь нь хариулж мэдэхгүй байна гэсэн байна.

График 32 Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн санал болгох төлөвлөгөө байгаа эсэх



Дараагийн жилээс ногоон хөгжлийг дэмжсэн ногоон бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж буй байгууллагуудын хувьд дийлэнх буюу 61 хувь нь ногоон автомашины зээл, 40 орчим хувь нь ногоон хэрэглээний зээл, бичил зээл, төслийн зээлийн бүтээгдэхүүн гаргана гэсэн байна.

График 33 Санал болгохоор төлөвлөж буй бүтээгдэхүүнүүд



Ногоон бичил санхүүгийн бүтээгдэхүүн гаргахад дараах асуудлууд хэр зэрэг сорилт болно гэж үзэж байна вэ? гэсэн асуултад эдийн засгийн таагүй нөхцөл байдал, байгаль орчны эрсдэлийг үнэлэх арга хэрэгсэл байхгүй, ногоон санхүүжилтийн талаарх заавар аргачлал, стандарт дутмаг мөн зээлийн эргэн төлөгдөх хугацаа урт байгаа нь хамгийн их бэрхшээл болно хэмээн хариулсан байна. Үр дүнг графикаар харуулбал дараах байдалтай байна.




График 34 Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн гаргахад тулгарч буй сорилтууд



Ногоон бичил санхүүгийн бүтээгдэхүүнийг санал болгох эсвэл бүтээгдэхүүн үйлчилгээний цар хүрээг тэлэхийн тулд ямар дэмжлэг чухал шаардлагатай гэж үзэж байна вэ? гэсэн асуултад ногоон санхүүжилтийг дэмжсэн татварын уян хатан бодлого, хууль эрхзүйн зохицуулалт, ногоон бичил санхүүжилтийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, байгаль орчны эрсдэлийг үнэлэх, удирдах талаар удирдамж заавар болон хүүгийн түвшинг бууруулахтай холбоотой төрөөс үзүүлэх дэмжлэг, судалгаа маш чухал хэрэгтэй гэж хариулсан байна. Үр дүнг графикаар харуулбал дараах байдалтай байна.

График 35 Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн санал болгоход шаардлагатай дэмжлэг



Эндээс үзэхэд судалгаанд оролцогчдын дийлэнх нь татварын бодлого, хууль эрхзүйн зохицуулалт, ногоон бичил санхүүгийн талаар мэдээлэл, сургалтууд, заавар аргачлал чухал байна гэж хариулсан байна.

Мөн ногоон бичил санхүүжилтийг нэвтрүүлэхтэй холбоотой нээлттэй асуултад судалгаанд оролцогчдын өгсөн хариултын ихэнх нь ногоон бичил санхүүгийн талаарх мэдлэг мэдээлэл, сургалт хэрэгтэй, мөн хямд санхүүгийн эх үүсвэр хомс, төрөөс татварын уян хатан зохицуулалт, хөнгөлөлт үзүүлэх, зохицуулагч байгууллагын зүгээс хэрэгжүүлэхэд тохиромжтой журам, заавар аргачлалаар хангах шаардлагатай байна гэж үзсэн байна.

## СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Сүүлийн жилүүдэд БСБ-ууд ядуурлыг бууруулах зорилгоос тогтвортой байдлыг хангах чиглэл рүү шилжиж эхэлсэн бөгөөд БСБ-ийн гол зорилго нь нийгмийн болон байгаль орчны хүчин зүйлүүдийг багтааж, тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хүчтэй арга хэрэгсэл болсон. Ногоон бичил санхүү нь “эдийн засаг, нийгэм, байгаль орчин” гэсэн гурван тулгуурт тогтвортой бичил санхүүгийн байгаль орчны зорилгыг хангахын тулд бага орлоготой иргэд, бизнес эрхлэгчдэд зээл олгох, байгаль орчны шалгуур зээлийг үнэлэх, болон техникийн туслалцаа буюу “ногоон” байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, технологийг авахад нь дэмжлэг үзүүлэх зэргээр ажилладаг.

Ногоон бичил санхүүгийн өнөөгийн байдлыг үнэлэхдээ Европын холбооны Бичил санхүүгийн платформын ажлын хэсгээс бичил санхүүгийн байгууллагуудын байгаль орчны хариуцлагыг бэхжүүлэх зорилгоор 2016 онд шинэчлэн боловсруулсан байгаль орчны гүйцэтгэлийн 4 стандарт, чанарын болон тоон 21 үзүүлэлт бүхий “Ногоон индекс 2.0” аргачлалыг ашигласан. Судалгаанд СЗХ-ноос гаргасан санхүүгийн салбарын статик мэдээнд үндэслэн 2019 оны байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 300 ББСБ-руу судалгаа илгээсэн боловч үүнээс 263 байгууллага судалгаанд хариу ирүүлсэн. Иймд судалгааны үр дүнг 263 ББСБ-уудын хувьд нэгтгэн гаргалаа.

- Судалгаанд хамрагдсан 263 ББСБ-уудын 99 хувь нь ХХК, 86 хувь нь УБ хотод үйл ажиллагаа явуулдаг, 79 хувь нь 10-аас доош жил үйл ажиллагаа явуулж буй бөгөөд 200 хүртэл зээлдэгчтэй байгууллагууд байсан.

- Судалгаанд оролцогчдын хувьд ногоон индексийн ерөнхий дундаж түвшин **0.146 оноо** буюу **14.6 хувиар** үнэлэгдсэн. Судалгаанд оролцогчдын дийлэнх буюу **71 хувь нь 20 хувиас бага үнэлгээтэй**, 19 хувь нь 20 оос 40 хувийн үнэлгээтэй, харин 10 хувь 40-өөс дээш хувийн үнэлгээтэй байна.
- Олон улсад “Ногоон индекс 2.0” загвараар хэмжсэн CERISE SPI4-н Ногоон индекс 29 хувь, MicroFinanza Rating-ийн ногоон индекс 48 хувьтай байна.
- Мөн 2011 оноос хойш MEPI загвараар хэд хэдэн судлаачид хөгжиж буй улс орнууд, европ болон төв Америкын улс орнуудын ББСБ-ын байгаль орчны гүйцэтгэлийг үнэлж судалсан байна. Үүнд M.Allet болон M.Hudon нарын хөгжиж буй 5 улсын 160 ББСБ дээр судалгаагаар БОГИ нь дунджаар 21 хувь, D.Forcella-ын Европын 36 улсын 59 ББСБ дээр судалгаагаар БОГИ нь дунджаар 21 хувь, ADA байгууллага төв Америкын 36 ББСБ дээр судалгаагаар БОГИ нь дунджаар 32 хувь гарсан.
- Эдгээр судалгааны үр дүнгүүдтэй харьцуулахад манай улсын ББСБ-уудын байгаль орчны гүйцэтгэлийн ногоон индекс **6-33 пунктээр** доогуур үзүүлэлттэй байгаа нь манай улсын хувьд ногоон бичил санхүүгийн хөгжил сул байгааг харуулж байна.
- Ногоон индексийн 4 стандартын хувьд байгаль орчны дотоод эрсдэлийг удирддаг байдал **хамгийн өндөр 21 хувь** байгаас ББСБ-ууд дотооддоо цаас, шатахуун, цахилгаан, ус хэмнэх болон хог хаягдлыг бууруулах, зардал хэмнэх оролдлого хийдэг үзэж болох юм. Харин байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг байдал **хамгийн муу 11 хувь**, мөн ногоон боломжийг дэмжиж урамшуулдаг байдал нь 13 хувь, ББСБ-ын байгаль орчны стратегия тодорхойлж удирддаг байдал нь 14 хувь байгаагаас ББСБ-уудын зээл санхүүжилт олгохдоо байгаль орчны эрсдэлийг тооцож үнэлэх эрсдэлийн удирдлага хангалтгүй, ногоон зээлийн бүтээгдэхүүний төрөлжилт хангалтгүй, зээлдэгч харилцагч нарт чиглэсэн үйл ажиллагаа үйл ажиллагаа хангалтгүй, мөн байгаль орчны асуудлын талаар баримтлах бодлого стратеги, процесс, компанийн нийгмийн хариуцлага, мэдээллийн ил тод нээлттэй байдал сул хөгжилтэй байна үзэж болохоор байна.
- “Ногоон индекс 2.0”-ын стандарт 1-ын хувьд хамгийн бага үзүүлэлт нь байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээ гадаад тайлан буюу олон нийтэд зориулсан жилийн тайландаа тайлагнадаг байдал 6.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Стандартын 2-ын хувьд

хамгийн бага үзүүлэлт нь ББСБ-ууд дотоод дах цаас, шатахуун, ус, түлшний хэрэглээг бууруулах ажлын гүйцэтгэлийг хянадаг байдал 19 хувь буюу хангалтгүй үнэлэгдсэн байна. Стандартын 3-ын хувьд хамгийн бага үзүүлэлт нь харилцагчийн байгаль орчны гадаад эрсдэлийг бууруулах, түүнийг таниулах ажиллагаа 8.7 хувь, мөн зээлдэгчийн байгаль орчны эрсдэлийг үнэлэхдээ тусгай арга хэрэгсэл ашигладаг байдал 8.9 хувь буюу хангалтгүй. Стандарт 4-ийн хувьд хамгийн бага үзүүлэлт нь ББСБ-ууд харилцагчиддаа өөрөө шууд эсвэл байгаль орчны байгууллагатай хамтрах замаар хэрхэн байгаль орчинд ээлтэй бизнес эрхлэх чиглэлээр сургалт явуулдаг байдал 6.3 хувийн гүйцэтгэлтэй байсан.

- “Ногоон индекс 2.0”-ийн чанарын үзүүлэлтийг тоон байдлаар нарийвчлан судалж үзвэл судалгааны асуулга дахь 5 шалгуур үзүүлэлтийг шийдвэр гаргахад маш чухал хэрэгцээтэй (47%), хянахад хялбар байна (35%) гэж илэрхийлсэн ч хянаж, хэрэгжүүлдэг байдал нь сул (19%) байна. Гэхдээ судалгаа бөглөж илгээсэн ажилтан нь дээрх үзүүлэлтүүдийг хэмжиж, хянадаг ажилтан биш байх магадлалтай учраас зарим байгууллагууд тоон үзүүлэлтээ илгээгээгүй эсвэл дутуу илгээсэн байж болзошгүй. Мөн тоон үзүүлэлтээ хэмжих хангалттай хөшүүрэг байхгүй хэмээн үзэж байна. Статистикийн шинжилгээгээр нийт судалгаанд оролцогчдын байгаль орчны гүйцэтгэлийн тоон үзүүлэлтээ хэмжиж тайлагнаж байгаа хэсэг нь маш бага ба цаашид ББСБ-уудын тоон үзүүлэлтээ хэмжиж тайлагнах, өөрсдийн шийдвэр гаргалтдаа ашиглахыг идэвхжүүлэх ажлууд хийх, улмаар байгууллага бүр хөгжлийн зорилгодоо байгаль орчны стратегия нэгтгэх ажилд нь зохицуулах байгууллагын оролцоо, дэмжлэг чухал гэж үзэж байна.
- Судалгаанд оролцогчид ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчиддаа санал болгох төлөвлөгөө байгаа (23%) боловч гол тулгамдаж буй асуудал эдийн засгийн таагүй нөхцөл байдал, байгаль орчны эрсдэлийг үнэлэх арга хэрэгсэл байхгүй, ногоон санхүүжилтийн талаарх заавар аргачлал, стандарт дутмаг байдал. Харин судалгаанд оролцогчдын дийлэнх нь татварын уян хатан бодлого, хууль эрхзүйн зохицуулалт, ногоон бичил санхүүгийн талаар мэдээлэл, сургалтууд, байгаль орчны эрсдэлийг үнэлэх заавар аргачлал, хямд санхүүгийн эх үүсвэр татах боломж нөхцөлөөр хангах чухал хэрэгтэй байна гэж үзсэн цаашид ногоон хөгжлийг дэмжсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломжтой үзсэн байна.

Дээрхээс нэгтгэн дүгнэхэд манай улсын ББСБ-ын байгаль орчны

гүйцэтгэл хэдий хангалтгүй байгаа ч ББСБ-уудын хувьд татварын уян хатан бодлого, зохицуулалт, хямд санхүүгийн эх үүсвэр татах боломжоор хангах болон ногоон санхүүжилтийн талаарх мэдлэг, мэдээлэл олгох, сурталчлах, мөн ББСБ-ын удирдлага болон ажилтнуудыг сургаж хөгжүүлэх замаар ногоон хөгжлийг дэмжсэн санаачлагуудыг дэмжих, ногоон бичил санхүүг хөгжүүлэх бүрэн боломжтой байна гэж үзэж байна.

## САНАЛ ЗӨВЛӨМЖ

Судалгааг ББСБ-уудын ногоон бичил санхүүгийн өнөөгийн байдлыг тодорхойлох, тулгамдаж асуудал бэрхшээл, ногоон санхүүгийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх боломжийг судлах зорилгоор хийсэн. Судалгааны эцэст ББСБ-уудын ногоон санхүүгийн өнөөгийн байдал сул, байгаль орчны гүйцэтгэлийн ногоон индекс хангалтгүй байгаа тул ногоон санхүүжилтийн хөгжүүлэхийн тулд дараах зүйлсэд анхаарах хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд:

### Зохицуулагч байгууллагуудын хувьд

- Цаашид “Ногоон индекс 2.0” аргачлалыг ашиглан ББСБ-уудын байгаль орчны гүйцэтгэлийг хэмжиж, ахиц дэвшлийг тогтмол мэдээлэх;
- ББСБ-уудын байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулах, уур амьсгал, байгаль орчны асуудалд хандах үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- ББСБ-уудын уур амьсгал, байгаль орчны асуудалд хандах үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, ногоон боломжийг дэмжихтэй холбоотой хууль, эрхзүйн зохицуулалтыг бий болгох;
- Ногоон бичил санхүүгийн талаар ББСБ-ууд, бичил бизнес эрхлэгч, олон нийтэд сурталчлах, мэдээлэл түгээх компанит ажил зохион байгуулах;
- “Байгаль орчин, нийгмийн удирдлагын систем”-ын талаар баримтлах бодлого, заавар, аргачлалыг боловсруулах;
- ББСБ-уудад зориулсан байгаль орчны гүйцэтгэлийн тайлагналын шаардлагуудыг боловсруулах;

- ББСБ-уудын санхүүжүүлэх, хөрөнгө оруулах боломжтой ногоон бүтээгдэхүүн үйлчилгээний жагсаалтыг боловсруулах;
- ББСБ-уудад ногоон хөрөнгө оруулалт татах боломжийг бий болгох;
- Мэргэжлийн байгууллага, холбоод болон олон улсын байгууллагуудтай хамтран ногоон боломжийг дэмжиж урамшуулах тогтолцоо бүрдүүлэх.

#### ББСБ-уудын хувьд

- Байгаль орчныг хамгаалах талаар алсын хараа, эрхэм зорилго, стратегидаа тусгах;
- Байгаль орчны асуудалтай холбоотой баримтлах албан ёсны бодлого, процедур, дүрэм журмыг боловсруулах;
- Байгаль орчинд ээлтэй, ногоон бүтээгдэхүүн үйлчилгээг санхүүжүүлэх талаар баримтлах бодлоготой байх;
- Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг удирдах ажилтныг томилох, сургаж хөгжүүлэх;
- Байгаль орчны гүйцэтгэл, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар тогтмол, ил тод нээлттэй мэдээлдэг байх;
- Компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, мэдээллийн ил тод тайлагналын системээ сайжруулах;
- “Ногоон индекс 2.0” аргачлалын дагуу байгаль орчны гүйцэтгэлийн өөрийн үнэлгээг хийж, шаардлагатай сайжруулалтыг тухай бүр хийдэг байх.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Ahmed, M. (2016). Micro Takaful Insurance as a Tool to Guaranteeing Financing and Protecting Micro Enterprises. *Journal of Business & Financial Affairs*, 05. 10.4172/2167-0234.1000228.

Allet, M. (2015). Green microfinance: Characteristics of Microfinance Institutions Involved in environmental management. *Journal of Business ethics*.

Forcella, D. (2013). European Green Microfinance: A first look. EMN Research. group, e.-M. M. (2016). The Green Index 2.0 An innovative tool to assess environmental performance in the microfinance sector.

Passerelles, A. (2014). MFIS' environmental performance in Central America under a context of climate change .

С.Дашдорж. (2019). Тогтвортой санхүү. Улаанбаатар хот.

СЗХ. (2019). Үйл ажиллагааны тайлан 2019. Улаанбаатар.

Allet, M. (2015). Measuring the environmental performance of microfinance: a new tool.

E-MFP Assessing Green Microfinance: Qualitative and Quantitative indicators for measuring environmental performance

СЗХ. (2020). Үйл ажиллагааны хагас жилийн тайлан 2020. Улаанбаатар



